

ЗУРГАА. ЦААЗААР АВАХ ЯЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur)
----------------	--

Судалгааны багийн бусад гишүүд:

С.Сүхбаатар	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
Б.Энх-Амгалан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Т.Намуун	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааны лавлагааг гүйцэтгэсэн:

Х.Ариунсүрэн	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Буянбат	Эрдэм шинжилгээний ажилтан
Д.Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
З.Мөнгөлжин	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Мөнгөнчимэг	Эрдэм шинжилгээний ажилтан
С.Мягмарсүрэн	Эрдэм шинжилгээний ажилтан
А.Намуунаа	Эрдэм шинжилгээний ажилтан
Х.Санчир	Эрдэм шинжилгээний ажилтан
Р.Хатансайхан	Эрдэм шинжилгээний ажилтан
О.Энххүслэн	Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг гүйцэтгэж хүргүүлсэн огноо: 2022.07.22.

АГУУЛГА

УДИРТГАЛ	319
НЭГ. МОНГОЛ УЛС ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛСАНТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ, ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ	323
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙН 1 ДЭХ ХЭСГИЙН ТУХАЙ СУДЛААЧДЫН ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ	327
ГУРАВ. ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛСАН УЛС ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЦААЗААР АВАХ ЯЛТАЙ ХОЛБООТОЙ ХЭМ ХЭМЖЭЭ -ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ	331
ДҮГНЭЛТ	338
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	340
НОМ ЗҮЙ	342
Хавсралт 1. Цаазаар авах ялтай холбоотой зарим эх сурвалжийн лавлагаа	345
Хавсралт 2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт ii протоколд нэгдсэн орнуудын үндсэн хууль болон эрүүгийн хууль дахь цаазаар авах ялтай холбоотой хэм хэмжээний лавлагаа	348

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд Монголын ард түмэн ... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, ... хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон. Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтын түгээмэл хэлбэрт олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, олон улсын гэрээ зүй ёсоор багтана. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.” гэж томьёолсон.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан. Төр энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, олон улсын гэрээг үндэсний эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болгох арга механизмыг өргөн ашиглаж байна.

“Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.”¹ гэдгээ илэрхийлэхийн зэрэгцээ “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”², “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”³, “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй”⁴ хэмээн Үндсэн хуульдаа баталгаажуулсан. Эдгээр нь олон улсын гэрээнд нэгдэн ороходоо хариуцлагатай хандах, нэгэнтээ нэгдсэн тохиолдолд үүргээ заавал биелүүлэх ёстой учир нухацтай судалсны үндсэн дээр шийдвэр гаргах тухай гүн утгыг агуулж байна. Мөн олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний эрх зүйд хэрэглэхтэй холбоотой гол үзэл баримтлал болдог.⁵

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, олон улсын эрх зүйн хөгжлийн нөлөөгөөр Монгол Улсад хүний эрхийн хамгааллын тогтолцоо сайжирч ирсэн. Тухайлбал, цаазаар авах ялыг хэрэглэж, халсан хэрнээ сэргээж байсан эрх зүйн түүх Монгол Улсын хувьд ард үлдсэн. Энэ нь цаазаар авах ялыг хүний эрхэм байдал, хүний эрх, тухайлбал амьд явах эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх, үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн эрх зүй, ялын бодлого, эрх зүйн түүх, уламжлал, шинэчлэл, олон улсын эрх зүйн хөгжил, олон улсын гэрээний үүрэгтэй холбон судалж ирсэн эрдэм шинжилгээний ажлын үр нөлөөтэй салшгүй холбоотойг эх сурвалжууд⁶ өгүүлж байна.

1 Монгол Улсын Үндсэн хууль, 10.4 дэх хэсэг.

2 Мөн зүйлийн 2 дахь хэсэг.

3 Мөн зүйлийн 3 дахь хэсэг.

4 Монгол Улсын Үндсэн хууль, 16.14 дэх хэсэг.

5 Б.Энх-Амгалан, “Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудал”, *Хууль дээдлэх ёс*, №3 2010 он, Холбоос: https://nli.gov.mn/pdf/olon_ulsin_gereend_negden_oro.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.28.

6 Судалгааны Хавсралт 1 -аас үзнэ үү. Мөн тус судалгааны 1 дүгээр бүлгийн “Цаазаар авах ял судлалын тухай” хэсгээс тоймлон үзнэ үү.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр цаазаар авах ялын гүйцэтгэлд мораторий тогтоож байгааг зарласан. Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хороо уг ялыг халахыг зөвлөснөөр Монгол Улс 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протокол-ыг соёрхон баталж, Монгол Улс цаазын ялыг хэрэглэхгүй байх үүргийг олон улсын өмнө хүлээсэн. Энэхүү протоколд нэгдэн орсон аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд хэний ч цаазалж үл болно; Оролцогч улсууд өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд цаазаар авах ялыг халахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна гэсэн үүрэг хүлээдэг.

2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-д уг ялыг тусгалгүй, ялын төрлөөс хассан. Ийнхүү Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлж, цаазын ялгүй улсын тоонд албан ёсоор орсон нь үндэсний эрх зүйн хөгжлийн түүхэн үе, хүний эрхийн дэвшил болсон юм.

Харамсалтай нь, олон улсын гэрээнд нэгдэж цаазаар авах ялыг халсан үйлдлийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх, түүнчлэн тухайн олон улсын гэрээнээс татгалзан гарах замаар цаазаар авах ялыг сэргээж, буцаан хэрэглэх тухай үзэл бүхий үйл явц өрнөсөн. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, цаазаар авах ялыг сэргээн хэрэглэх тухай саналыг ХЗДХ-ийн сайдад хүргүүлсэн⁷. Уг саналтай холбогдуулан ХЗДХЯ-аас, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий Прокурорын газар, Хуульчдын холбоо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Гадаад харилцааны яам, МУИС-ийн багш нараас төлөөлөл оролцуулсан ажлын хэсэг байгуулж судлуулахад 100 хувь санал нэгтгэйгээр Монгол Улс цаазаар авах ялыг сэргээх, ИБУТЭТОУП-ын Нэмэлт II протоколоос гарах хууль зүйн үндэслэл байхгүй гэсэн дүгнэлтийг Ажлын хэсэг гаргажээ⁸.

Үүний зэрэгцээ хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон үндэсний хэмжээний байгууллага, судалгааны институт, их сургуулиуд, эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн зүгээс Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколыг соёрхон баталсан нь Үндсэн хууль зөрчөөгүй; Монгол Улс тухайн олон улсын гэрээнээс татгалзан гарч, цаазаар авах ялыг буцааж хэрэглэх боломжгүй гэдгийг онол, практикийн төвшинд судалж дүгнэн, хэлэлцүүлэг зохион байгуулж, өгүүлэл, илтгэл хэвлэн нийтлүүлэх хэлбэрээр нөлөөллийн ажиллагаа багагүй хийсэн байна. Тухайлбал, Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас эрдэмтэн судлаачид, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын мэргэжилтнүүд, их дээд сургуулиудын улс төр судлал, эрүүгийн эрх зүйн болон олон улсын эрх зүйн багш, доктор, профессоруудыг урьж 2018 оны 9-р сарын 20-ны өдөр “Үндсэн хууль ба цаазаар авах ял” сэдвээр, 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Улс төр ба цаазаар авах ял” сэдвээр тус тус хэлэлцүүлэг зохион байгуулж, эрх зүйн хүрээнд үүссэн маргаантай асуудлын шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

7 “Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга бага насны хүүхдийг хүчирхийлсэн, амийг нь хөнөөсөн балмад хэрцгий аллагын гэмт этгээдүүдэд цаазаар авах ялыг сэргээн хэрэглэх тухай саналаа ХЗДХ-ийн сайд Ц.Нямдоржид хүргүүлээ,” Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, 2017.11.27, Холбоос: <http://www.president.mn/content/12741>.

8 “Цаазаар авах ялыг сэргээх хууль зүйн боломжгүй гэсэн дүгнэлт гаргажээ,” news press, 2018.03.30, Холбоос: <https://newspress.mn/v1/p/news/3477>.

Гэвч дээр дурдсан үйл ажиллагаанууд зөвхөн мэргэжлийн хүрээнд явагдсан байгаа нь цаазаар авах ялыг сэргээвэл хүнд гэмт хэргүүдийн тоо багасна гэсэн зарим иргэдийн үзэл бодол хэвээр үлдэхэд нөлөөлсөн байх талтай. Өөрөөр хэлбэл олон улсын гэрээнд нэгдэж цаазаар авах ялыг халсан нь эргээд олон улсын гэрээний үүргийн харилцаа үүсгэдэг зэрэг зарчмын асуудлыг иргэд төдийлөн сайн мэдэхгүй байгаатай холбоотой байх магадлалтай юм.

Эрдэмтэн судлаачид, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколыг соёрхон баталсан нь Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг хийхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно”⁹ гэсэн заалтыг тал бүрээр тайлбарлажээ. Харин цаазаар авах ялыг халсантай холбогдуулан Үндсэн хуулийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх асуудлаар дүгнэлт хийж, санал гаргасан байдал хэвлэн нийтлэгдээгүй байна.

Энэ хэрэгцээ, шаардлагыг харгалзан, цаазаар авах ялтай холбоотой эрх зүйн хүрээний зарим асуудлыг нэгтгэн дүгнэж, олон улсын эрх зүйн зохицуулалт болон гадаад орнуудын чиг хандлагыг харгалзах замаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх судалгааны ажлын захиалгыг ХЗДХЯ-аас ирүүлсэн болно.

Судалгааны зорилго. Цаазаар авах ялыг халахтай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалт, гадаад орнуудын чиг хандлага, Монгол Улсын эрх зүйн хүрээний зарим асуудлыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулах ажлын хэрэгцээнд зориулж лавлагаа мэдээлэл, санал, зөвлөмж боловсруулж дэмжлэг үзүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт. Энэхүү судалгаа дараах зорилттой. Үүнд:

1. Монгол Улс цаазаар авах ялыг халсны дараа үүссэн эрх зүйн хүрээний зарим асуудлыг нэгтгэн дүгнэж, лавлагаа бэлтгэх;
2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн талаарх судлаачын тайлбарыг нэгтгэн дүгнэж, лавлагаа бэлтгэх;
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдсэн улс орнуудын Үндсэн хууль болон Эрүүгийн хууль дахь цаазаар авах ялтай холбоотой зохицуулалтыг түүвэрлэж лавлагаа бэлтгэх, түүнд тулгуурлан дүн шинжилгээ хийх;
4. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулах чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээний санал, зөвлөмж дэвшүүлэх.

9 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, Холбоос: <https://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.30.

Судалгааны арга зүй. Монгол Улс цаазаар авах ялыг халсны дараа үүссэн эрх зүйн хүрээний зарим асуудлын онолын үндэслэлийг нэгтгэн дүгнэх болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдсэн улс орнуудын Үндсэн хууль дахь цаазаар авах ялтай холбоотой зохицуулалтыг түүвэрлэж, дүн шинжилгээ хийх хүрээнд баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, хууль зүйн техник, хууль тайлбарлах зэрэг судалгааны арга; Санал, зөвлөмж боловсруулах зорилтын хүрээнд индукц, дедукцийн нэгдэл зэрэг логик арга зүйг энэхүү судалгаанд ашиглав.

Судалгааны хамрах хүрээ. Судалгааг олон улсын эрх зүйн болон Үндсэн хуулийн эрх зүй, Эрүүгийн эрх зүйн онол, арга зүй, туршлагад тулгуурлан холбогдох олон улсын эрх зүйн хэм хэмжээ, эх сурвалж болон ИБУТЭТОУП-ын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдсэн улс орнуудын Үндсэн хууль болон Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтын хүрээнд явуулав. Эдгээр орнуудын Үндсэн хууль дахь цаазын ялтай холбоотой хэм хэмжээг түүвэрлэж, агуулгаар нь ангилж бүлэглэн, онцлог зохицуулалтыг тодруулав. Цаазаар авах ялын талаарх онолын ойлголт, хэрэглэж ирсэн түүх, уг ялыг халахтай холбоотой болон халах нь зөв гэсэн асуудлыг хөндсөн судалгаа шинжилгээний ажил дотоодын хэмжээнд хангалттай хийгдсэн учир эдгээр асуудлыг уг судалгаанд хамруулаагүй болно. Харин олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлэх чиглэлээр хууль зүйн бодлогын хүрээнд асуудал дэвшүүлж, шийдлийн хувилбар бүхий санал, зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэх хүрээнд, Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэж цаазаар авах ялыг халсны дараа үүссэн эрх зүйн хүрээний зарим асуудалд өгсөн эрдэмтэн судлаачдын үзэл бодлыг нэгтгэн дүгнэх, өмнө судлагдсан үр дүнг тусгах зэрэг хандлага баримтлав. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлоход харгалзан үзэх шаардлагатай асуудлуудыг дэвшүүлж, судалгаагаар дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд тус судалгааг хийв.

Судалгааны ажлын хүрсэн үр дүн. Цаазаар авах ялыг халахтай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалт, гадаад орнуудын хандлага, Монгол Улсын эрх зүйн хүрээний зарим асуудлыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулах ажлын хэрэгцээнд зориулж лавлагаа мэдээлэл, санал, зөвлөмж боловсруулав.

НЭГ. МОНГОЛ УЛС ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛСАНТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ, ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ

Цаазаар авах ял судлалын тухай. Монгол Улсын хувьд, цаазаар авах ял судлалыг уг ялыг халахаас өмнө ба хойш гэж хувааж авч үзэх ч боломжтой хэмжээнд хүрчээ. Энэхүү судалгаанд Монгол Улс цаазаар авах ялыг халсантай холбоотой эрх зүйн хүрээний цаашдын асуудлыг хамруулж байгаа хэдий ч Монгол Улсад, цаазаар авах ялын талаар судалсан зарим эх сурвалжийг цуглуулж, бодлого боловсруулах ажлын хэрэгцээнд зориулж лавлагаа бэлтгэв. Үүнд : Докторын зэрэг горилсон бүтээл 2 (шууд холбоотой дагнасан сэдвээр 1, дам холбоотой сэдвээр 1); Магистрын зэрэг хамгаалсан ажил – 13; Ном, гарын авлага, судалгааны тайлан, эмхэтгэл – 12; Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл – 26 багтаж байна. Эдгээр нийт 53 эх сурвалжийг 4 төрлөөр ангилж, зохиогчийн нэр, бүтээлийн нэр, огноо, хэвлэгдсэн газар, цахим холбоос зэрэг мэдээлэл бүхий лавлагааг Хавсралт 1-ээс дэлгэрүүлж үзнэ үү.

Цаазаар авах ялын талаар эрдэмтэн судлаачид, тухайлбал, Г.Совд, Б.Содовсүрэн, Ж.Авхиа, С.Нарангэрэл, Ж.Амарсанаа, Д.Баярсайхан, Б.Бат-Эрдэнэ, П.Оюунчимэг, С.Жанцан, О.Мөнхсайхан, Р.Очирбал, Г.Оюунболд, Агар-Эрдэнэ нар өөрсдийн судалгааны чиглэлийн хүрээнд, хэсэгчлэн судалж иржээ. Д.Амарбаясгалан “Цаазаар авах ял: Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал” нэг сэдэвт бүтээл туурвиж, докторын зэрэг хамгаалсан нь цаазаар авах ялын монгол судлалын хөгжлийг илэрхийлсэн бүтээлд тооцогдоно. Тэрээр цаазаар авах ялын талаарх онолын үзэл баримтлал, чиг урсгал, цаазаар авах ял ба эрүүгийн эрх зүйн эх сурвалж, гадаад орнуудын хандлага, Монгол Улсын уламжлал ба түүхэн сургамж, эрх зүйн асуудлыг онолын төвшинд гүнзгийрүүлэн судалжээ.

Цаазаар авах ялыг судалсан монгол эх сурвалжийн дотор хүний эрхтэй холбож судалсан бүтээлүүд дийлэнх хувийг эзэлж байгаа нь энэ төрлийн ялыг халахад чиглэсэн үзэл бодол Монголд хөгжиж ирснийг нотлох нэгэн үзүүлэлт юм.

Хүний эрхийн олон улсын нэр хүнд бүхий томоохон хөдөлгөөн болох “Эмнести Интернэшнл” байгууллагын Монгол Улс дахь салбар санаачилж эмхэтгэн боловсруулсан “Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял” сэдэвт товхимолд Монгол Улс дахь хүний амьд явах эрх ба түүний эрх зүйн баталгаа; Монгол Улсад цаазаар авах ялыг хэрэглэсэн байдлын судалгаа (түүхэн тойм); цаазаар авах ял ба улс төрийн хэлмэгдэл; Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ял; Цаазаар авах ял ба Монголын шүүхийн практик; Цаазаар авах ялтай хэргийн Монгол Улс дахь шүүн таслах ажиллагаа; Цаазаар авах ялын дэлхий дахины нийтлэг чиг хандлага зэрэг асуудлыг хөндсөн. Түүнчлэн цаазаар авах ялын талаар тандалтын судалгааг мэргэжлийн хуульчид ба иргэдийн дунд явуулсан. Энэхүү судалгааг Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 4344 иргэн, 558 хуульч буюу, өөрөөр хэлбэл 5 мянга шахам хүний дунд явуулсан болно. Энэ товхимол нь Монгол Улс цаазаар авах ялыг халахаас өмнөх нөхцөл байдлыг тоймлон дүгнэж, цаазаар авах ялын дэлхий дахины чиг хандлагыг дурдаж, уг ялын талаар Монгол Улсын баримтлах бодлогод зөвлөмж дэвшүүлснээрээ ач холбогдолтой.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас 2018 оны 9-р сарын 20-ны өдөр эрдэмтэн судлаачид, хууль зүйн их дээд сургуулиудын эрүүгийн эрх зүйн

болон олон улсын эрх зүйн багш, доктор, профессоруудыг урьж, зохион байгуулсан “Үндсэн хууль ба цаазаар авах ял” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэлд цаазаар авах ял ба Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн холбоо хамаарлыг онол, практикийн төвшинд дүгнэсэн тайлбар, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг хэвлэн нийтэлсэн байна. Үүнд, Монголын Эмнести Интернэшнл байгууллагын байр суурь, тайлбар, мэдээллээс гадна хөндлөнгийн судлаачдын байр суурь бүхий илтгэлүүд багтсан. Эдгээр илтгэлүүд нь Монгол Улс цаазаар авах ялыг халснаас хойш үүссэн, ялангуяа уг ялыг халсантай холбоотой үүссэн эрх зүйн маргаантай асуудлыг онолын үндэслэлтэй тайлбарлан дүгнэжээ. Иймээс судалгааны хүрээг харгалзан, уг эмхэтгэлд багтсан илтгэлүүдээс холбогдох гол дүгнэлтүүдийг тоймлон авч үзье.

Цаазаар авах ялыг халсны дараа үүссэн асуудал, холбогдох тайлбар, дүгнэлт

Нэр бүхий иргэдээс Үндсэн хуулийн цэцэд хандсан асуудал буюу, Улсын Их Хурлаас 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр баталсан, ИБУТЭОУП-ын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай Монгол Улсын хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай асуудлаар Монголын Эмнести Интернэшнл байгууллага байр сууриа илэрхийлж, дараах тайлбарыг өгсөн. Үүнд: ИБУТЭОУП-ын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай Монгол Улсын хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй; Цаазаар авах ялыг сэргээх нь хүний эрхийн зөрчил мөн бөгөөд хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан эрх зүйн байдлыг дордуулсан явдал болно; Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколыг цуцлах нь хууль зүйн хувьд боломжгүй; Цаазаар авах ял шийдэл биш, тиймээс ялын бодлогод байх ёсгүй; Цаазаар авах ялыг халснаар онц хүнд гэмт хэргийн гаралт өссөн гэдэг нь нотлогдоогүй гэсэн тайлбарууд¹⁰ багтсан. Эдгээр нь шинжлэх ухаан, практикийн тайлбар бүхий дүгнэлт юм.

Хууль зүйн доктор О.Мөнхсайхан “Цаазаар авах ялыг сэргээвэл олон улсын хууль төдийгүй үндсэн хууль зөрчинө”¹¹ сэдэвт илтгэлдээ цаазаар авах ялыг хэрэглэж ирсэн Монгол Улсын түүх, халахад чиглэсэн санал санаачилга болон төрийн бодлого, эрх зүйн түүх, үндэслэл, ач холбогдлын талаарх судалгааны үр дүнгээ тоймлож, уг ялыг сэргээх тухай үзэл бодлын эсрэг няцаалт бүхий онолын үндэслэлтэй тайлбар хийжээ. Тэрээр Монгол Улс цаазаар авах ялыг халсан нь Үндсэн хуульд нийцсэн зөв алхам байсан бөгөөд уг ялыг сэргээх хууль зүйн боломжгүй гэдгийг онцолж, дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд: Цаазаар авах ялыг халах тухай Нэмэлт II протоколоос Монгол Улс гарах боломжгүй учраас олон улсын хуулийг зөрчихгүйгээр цаазаар авах ялыг сэргээх боломжгүй; Цаазаар авах ял заавал байх агуулга Монгол Улсын Үндсэн хуульд байхгүй төдийгүй уг ял нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний нэр төр халдашгүй байх эрх, амьд явах эрх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг ноцтой зөрчдөг учраас уг ял нь Үндсэн хуулийн бус байсан. Мөн,

10 Р.Очирбал, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орох тухай Монгол улсын хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаарх маргаантай холбогдуулан гаргасан Монголын Эмнести Интернэшнл байгууллагын байр суурь, тайлбар, мэдээлэл”, *Үндсэн хууль ба цаазаар авах ял хэлэлцүүлгийн эмхэтгэл*, (УБ, 2018), 3-11 дэх талаас дэлгэрүүлж үзнэ үү.

11 “Үндсэн хууль ба цаазаар авах ял” хэлэлцүүлгийн эмхэтгэл, (УБ, 2018), 13-40 дэх талаас дэлгэрүүлж үзнэ үү.

энэ үндэслэлийг зөвшөөрөхгүй олон хүний хувьд гэм буруугүй хүнд цаазаар авах ялыг хэрэглэх боломж ямагт байдаг гэсэн шалтгаанаар уг ялыг халахыг дэмждэг; Энэ ял нь онц хүнд гэмт хэргийн гаралтыг бүх насаар хорих ялаас илүү үр нөлөөтэйгөөр бууруулдаггүйг олон судалгаа нотолдог гэсэн дүгнэлтүүд багтжээ.

2000 оноос хойш 20 шахам жилийн хугацаанд УИХ-ын дөрвөн өөр бүрэлдэхүүний олонх цаазаар авах ялыг халахыг хүлээн зөвшөөрч дэмжиж, хэрэгжүүлж ирсэн үйл явц нь Монголын улс төрийн намууд, лидерүүд, хуульчид, судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр дүн, ардчилсан нийгмийнхээ суурь үнэт зүйлийг хамгаалахад хийсэн чухал шинэчлэл болсон гэдгийг мөн түүхчлэн дүгнэсэн. Монгол Улс Үндсэн хуулиараа хүний нэр төр халдашгүй байх, амьд явах, эрүү шүүлтээс ангид байх эрхүүдийг суурь үнэт зүйл хэмээн хүлээн зөвшөөрч хамгаалдаг. Гэвч, цаазаар авах ял эдгээр суурь үнэт зүйлсийг бүгдийг нь ноцтой зөрчдөг; АИХ-ын төлөөлөгчид Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг батлахдаа ямар санаа бодолтой байсан хийгээд Үндсэн хуулийн тухайн бичиглэлийг хэрхэн тайлбарлах арга зүйн талаар дурдаж, Үндсэн хуулийн угчилсан болон үгчилсэн тайлбар: цаазаар авах ялыг бүр мөсөн халахыг Үндсэн хуулиар зөвшөөрдөг; Үндсэн хуулийн ёс суртахууны тайлбар: бүх тохиолдолд цаазаар авах ял Үндсэн хууль зөрчдөг; Цаазаар авах ял хүний нэр төрийг үгүй хийдэг; Цаазаар авах ял хүний амьд явах эрхийг зөрчиж хүний хувьд эдлэх бүх эрхийг нь үгүйсгэдэг; Цаазаар авах ял бол эрүү шүүлтийн ноцтой хэлбэр; Гэм буруугүй хүнийг цаазлах боломж ямагт байдаг; Цаазаар авах ялыг бүрэн халахгүйгээр ямар ч эрх зүйн тогтолцоонд гэм буруугүй хүнд ял өгөх эрсдэлийг арилгаж чадахгүй бөгөөд гэм буруугүй хүнд цаазаар авах ял оногдуулж гүйцэтгэсэн тохиолдолд уг гэм буруугүй хүний амьд явах үндсэн эрхийг дахин сэргээх боломж байхгүй; Цаазаар авах ял нь онц хүнд гэмт хэргийн гаралтыг бусад ялаас илүү бууруулдаггүй гэсэн дүгнэлтүүдийг онолын үндэслэл, практик жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарласан.

Судлаач Г.Оюунболд “Онц ноцтой гэмт хэргийн гаралт түүнд нөлөөлөх хүчин зүйл” сэдэвт илтгэлдээ “Цаазаар авах ял нь нөхөн сэргээх боломжгүй ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр бөгөөд төр хариуцлагаас зугтаж байгаа буруу жишиг гэж үздэг болсон. Иймээс хэрэв хангалттай нотолгоогүйгээр цаазаар авах ял оногдуулсан бол энэ нөхөн сэргээх боломжгүй хүний эрхийн хамгийн том зөрчил болдог; Ял шийтгэлийн бодлогын хувьд цаазаар авах ял байснаар цээрлэл үзүүлэх, урьдчилан сэргийлэх нөлөөлөл хэрэгжиж байгаа гэсэн ямар ч үндэслэл нотолгоо тогтоогдсонгүй. Ял шийтгэлийн бодлого хатуу байснаар хэргийн гаралт буурсан тухай криминалоги судалгааны нэг ч тайлан байхгүй байна. Гэмт хэргийн статистик мэдээнээс үзвэл сүүлийн 10 жилд гарсан онц хүнд гэмт хэргийн гаралт тогтвортой байгаа төдийгүй ял шийтгэлийн бодлого зөөлөрч тухайн гэмт хэрэг үйлдсэн хүнтэй ажилласнаар эерэг хандлага ажиглагдаж байна.”¹² гэж дүгнэн Монгол Улс цаазаар авах ялыг халсны ач холбогдол хийгээд цаашид энэ ялын төрлийг сэргээн хэрэглэх ямар ч ашиггүй бөгөөд эрх зүйн хувьд тийм боломжгүй талаар үзэл бодлоо тусгасан.

Судлаач Г.Агар-Эрдэнэ “Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоос оролцогч улс буцаж гарах боломжтой юу?” өгүүлэлдээ ИБҮТЭТОУП-ын II Нэмэлт Протоколоос буцаж гарах

12 Г.Оюунболд, “Онц ноцтой гэмт хэргийн гаралт, түүнд нөлөөлөх хүчин зүйл”, “Үндсэн хууль ба цаазаар авах ял” хэлэлцүүлгийн эмхтгэл, 41-46 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү, (УБ, 2018) Холбоос: https://www.academia.edu/37810480/ҮНДСЭН_ХУУЛЬ_БА_ЦААЗААР_АВАХ_ЯЛ

хууль зүйн боломж байхгүй болохыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээнд үндэслэн тайлбарласан. Тэрээр ИБУТЭТОУП, түүний II Нэмэлт Протоколд хүний амьд явах эрх, цаазаар авах ялыг халах асуудлыг хэрхэн зохицуулсан талаар, түүнчлэн уг Нэмэлт Протоколоос оролцогч улс буцаж гарах асуудал олон улсын эрх зүйн хүрээнд хязгаарлагдсан тухай тус тус авч үзсэн. Монгол Улс Цаазаар авах ялыг халах тухай ИБУТЭТОУП-ын II Нэмэлт Протоколоос буцаж гарах боломжгүй, уг олон улсын гэрээ нь буцаж гарах заалт агуулаагүй бөгөөд энэ төрлийн олон улсын гэрээнээс буцаж гарах боломжгүй болохыг Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцийн холбогдох заалт болон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 26 дугаар Ерөнхий зөвлөмжөөр зохицуулсан болно¹³ хэмээн дүгнэжээ.

Дээр дурдсан эрдэмтэн судлаачид нь Монгол Улс, цаазаар авах ялын тухайд өнөөгийн хүрсэн хөгжлийн түвшин, байр суурь, амжилтаасаа ухрах ёсгүй гэдэгтэй санал нэгдсэн байна. Эдгээр дүгнэлтийг хийхдээ цаазаар авах ял судлалын түүхэн хөгжил, үр нөлөөнд суурилан, уг ялаас татгалзаж буй олон улсын чиг хандлагад тулгуурлан, цаазаар авах ялыг халсан эрх зүйн үндэслэлийг олон улсын эрх зүйн ба Үндсэн хуулийн эрх зүйн онолын төвшинд тайлбарласныг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэж цаазаар авах ялыг халсан нь Үндсэн хууль зөрчөөгүй хэмээн дүгнэлт хийхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1-д Монгол Улсын иргэн “амьд явах эрхтэй,” “Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэж заасныг судлаачид олон талаар тайлбарласан байв. Эдгээр тайлбарт бусад эрдэмтэн судлаачдын хувьд дээрх заалтыг тайлбарласан дүгнэлтийг мөн хэрхэн тусгасныг авч үзье.

13 Г.Агар-Эрдэнэ, “Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоос оролцогч улс буцаж гарах боломжтой юу?”, “Үндсэн хууль ба цаазаар авах ял” хэлэлцүүлгийн эмхтгэл, (УБ, 2018), 47-55 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү, Холбоос: https://www.academia.edu/37810480/ҮНДСЭН_ХУУЛЬ_БА_ЦААЗААР_АВАХ_ЯЛ

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙН 1 ДЭХ ХЭСГИЙН ТУХАЙ СУДЛААЧДЫН ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын иргэн бүр “амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэж заасан. Энэ заалтын дагуу зөвхөн Эрүүгийн хуульд заасан тохиолдолд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ял оногдуулж болох бөгөөд бусад бүх тохиолдолд цаазаар авах ялыг хориглосон гэж ихэнх судлаачид, хуульчид үздэг.¹⁴

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн анхны дарга, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд “Монгол Улсын Үндсэн хуульд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах ялыг зөвхөн хуульд /эрүүгийн цааз/ заасан тохиолдолд оногдуулж болохыг зөвшөөрсөн явдал бол Монгол Улсын эрүүгийн цаазад цаазаар авах ялыг үүрд хадгалахыг хүлээн зөвшөөрсөн заалт биш учраас энэ заалт нь цаазаар авах ялыг устгахад өчүүхэн ч саад болохгүй”¹⁵, Үндсэн хуулийн эхийг баригч, доктор, профессор Б.Чимид “...засаг төр хууль бусаар, зоргоор хүний амь бүрлэгвээс хүний энэхүү үндсэн эрхийг хөсөрдүүлээ хэмээн тооцно”², МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, доктор Д.Солонго “Монгол Улсын Үндсэн хуулийн “...Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулах” тухай заалтын агуулга НҮБ-ын хүчин төгөлдөр үйлчилж буй баримт бичигт харшлахгүй. Учир нь тэдгээр баримт бичиг уг асуудлыг шийдвэрлэх нь үндэсний хууль тогтоомжийн эрх хэмжээнд хамаарна гэсэн зарчимд үндэслэхийн хамт дэлхийн хамтыннийгэмлэгийн улсуудыг цаазаар авах ялыг хязгаарлах, аажмаар халах явдалд чиглүүлж байдагт оршино”¹⁶ гэж тус тус үзжээ.

Цаазаар авах ял судлалын чиглэлээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан Д.Амарбаясгалан “1992 оны ардчилсан Үндсэн хууль батлагдсанаар хүний амьд явах эрхийг Үндсэн хуулийн түвшинд баталгаажуулж, тухайн эрхийг эдлүүлэх явдлыг төрийн үүрэг болгон хуульчилснаар цаазаар авах ялыг түгээмэл хэрэглэх хандлагыг цаашид хязгаарлах, улмаар хориглох эрх зүйн орчныг бий болгох анхдагч хүчин зүйл болж өгчээ”¹⁷; хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан “доктор, профессор Б.Чимид УИХ-аас 2003 онд баталсан Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулахад үндэсний зөвлөхөөр ажиллаж эхийг нь барьсан бөгөөд уг хөтөлбөрийн 2.1.1.1-т цаазаар авах ялыг “хэтдээ ялын төрлөөс хасах чиглэл” баримтлахаар заасан, иймээс доктор Б.Чимид тэргүүтэй судлаачид, хуульчдынхаар Үндсэн хуулийн хүрээнд цаазаар авах ялыг халах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг”¹⁸ хэмээн тус тус тайлбарласан нь цаазаар авах ялтай

14 О. Мөнхсайхан, “Цаазаар авах ялыг сэргээвэл олон улсын хууль төдийгүй үндсэн хууль зөрчинө”, *Үндсэн хууль ба цаазаар авах ял* хэлэлцүүлгийн эмхтгэл, 13-40 дэх тал.

15 Г.Совд, “Арван зургадугаар зүйл”, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 86 дахь тал; Дам эшлэв: О.Мөнхсайхан, “Цаазаар авах ялыг сэргээвэл олон улсын хууль төдийгүй үндсэн хууль зөрчинө”, 26 дахь тал.

16 Д.Солонго, “Арван зургадугаар зүйлийн 1, 2, 5, 6 дахь заалт”, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, (УБ, 2009), 67–71 дэх тал. Дам эшлэв: “Үндсэн хууль ба цаазаар авах ял” хэлэлцүүлгийн эмхтгэл, (УБ, 2018), 26 дахь тал.

17 Б.Амарбаясгалан, *Цаазаар авах ял: эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал*, (УБ, 2015), 133 дахь тал, Дам эшлэв: *Үндсэн хууль ба цаазаар авах ял* хэлэлцүүлгийн эмхтгэл, (УБ, 2018), 27 дахь тал.

18 О.Мөнхсайхан, “Цаазаар авах ялыг сэргээвэл олон улсын хууль төдийгүй үндсэн хууль зөрчинө”, *Үндсэн хууль ба цаазаар авах ял* хэлэлцүүлгийн эмхтгэл, (УБ, 2018), 26 дахь тал.

холбоотой Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хөндсөн дүгнэлт юм.

Хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн талаар тухайн үеийн АИХ-ын төлөөлөгчид ямар санаа бодолтой байсан хийгээд Үндсэн хуулийн текстийг хэрхэн тайлбарлах арга зүйн талаар товч тайлбарласан. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд үгчилсэн эсхүл угчилсан тайлбар төдийгүй ёс суртахууны тайлбар хийх хэрэгтэй, боломжтой талаар дурдаж, Үндсэн хуулийн ёс суртахууны тайлбарын хувьд “бүх тохиолдолд цаазаар авах ял Үндсэн хууль зөрчдөг” гэсэн дүгнэлт гарч ирнэ гэж үзсэн. Тэрээр:

“...Цаазаар авах ял заавал байх агуулга Монгол Улсын Үндсэн хуульд байхгүй төдийгүй Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний нэр төр халдашгүй байх эрх, амьд явах эрх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг ноцтой зөрчдөг учраас уг ял нь Үндсэн хуулийн бус байсан. Үндсэн хуулийн угчилсан болон үгчилсэн тайлбарын хувьд, цаазаар авах ялыг бүр мөсөн халахыг Үндсэн хуулиар зөвшөөрдөг; Монгол Улсын Үндсэн хуульд цаазаар авах ял гэх нэр томъёо хэрэглэгдээгүй бөгөөд цаазаар авах ял заавал байна гэсэн үгчилсэн утга байхгүй. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт зөвхөн “Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд” гэсэн нөхцөл хийсэн учраас Үндсэн хуулийн 25-р зүйлийн 1.1-д заасны дагуу УИХ хууль батлах онцгой бүрэн эрхтэйн хувьд ямар гэмт хэрэгт ялын дээд хэмжээ оногдуулахаар Эрүүгийн хуульд заахыг шийдвэрлэнэ. УИХ бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахаас татгалзсан Эрүүгийн хууль гаргасан. Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг халах эсэх нь хууль тогтоох эрх мэдлийн асуудал юм. Мөн, цаазаар авах ялыг халах тухай олон улсын гэрээнд нэгдэн орох тухай хууль батлах нь УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарна (Үндсэн хуулийн 10-р зүйлийн 3, 25-р зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 15). УИХ Нэмэлт II протоколд нэгдэн орох тухай хууль баталсан учраас Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулах агуулгатай хууль батлах УИХ-ын бүрэн эрх хязгаарлагдсан гэсэн үг. Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэр Эрүүгийн хуулиар онц хүнд гэмт хэрэгт оногдуулж болох ялын дээд хэмжээ нь цаазаар авах ял байж болно гэж нийтлэгээр ойлгож ирсэн бөгөөд энэ өгүүлбэр Монгол Улс цаазаар авах ялыг халахыг огт үгүйсгээгүй гэдэгт дийлэнх эрдэмтэд санал нэгддэг. Иймээс, Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэрт цаазаар авах ялыг заавал хуульчлах агуулга байхгүй.”

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэг нь ИБУТЭТОУП-ын холбогдох зүйлтэй төстэй хэллэгээр бичигдсэн учраас уг хэсгийг цаазаар авах ялыг халахыг хориглодог гэж тайлбарлах боломжгүй гэж мөн дүгнэн дараах харьцуулалтыг мөн тэрээр хийсэн. Энэ нь:

“...ИБУТЭТОУП-ын 6 дугаар зүйлд хүн бүр амьд явах эрхтэй, хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй, цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу этгээдэд оногдуулж болно, энэхүү ялыг гагцхүү эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно гэжээ. Үүнтэй хэллэгийн хувьд төстэй, адил санааг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний

учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэж товч байдлаар бичжээ. ИБУТЭТОУП-ын 6 дугаар зүйл нь цаазаар авах ялыг заавал байлгах агуулгагүй бөгөөд уг ялыг халахад ямар ч саад болдоггүй гэдгийг олон улсын эрх зүйд нийтлэгээр хүлээн зөвшөөрдөг. ИБУТЭТОУП-ын 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Энэхүү зүйлийн аль ч заалт нь энэхүү Пактад оролцогч аль нэгэн улс цаазаар авах ялаа халахыг хойшлуулах эсхүл зогсоох үндэслэл болохгүй” гэж энэ талаар тодорхой заасан... Тиймээс, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг уг пактын 6 дугаар зүйлтэй төстэй текстээр бичигдсэний хувьд адилхан цаазаар авах ялыг халахыг хориглодоггүй төдийгүй шаарддаг, дэмждэг гэж тайлбарлагдах ёстой.”

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа “Амьд явах эрхийг Үндсэн хуулиар хамгаалах нь”¹⁹ сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэлдээ “амьд явах эрх”-ийн тухай ойлголт, түүний агуулгыг шинээр тодорхойлох шаардлага гарч байна; Уг ойлголтын бүрдүүлбэрийг бүрэн дүүрэн тодорхойлох нь тус эрхэд хамаарах хуулиуд алдаагүй, хийдэлгүй гарах нөхцөлийг бүрдүүлнэ; Энэхүү эрхийн агуулгыг зөв шинэчлэх нь үндсэн хуулийн эрх зүй болон бусад салбар эрх зүйг хооронд нь мөн зааглах, мөн уялдуулах боломжийг олгоно гэсэн нь Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт хамаатай дүгнэлт юм.

Тэрээр хүний амьд явах эрхийг Үндсэн хуульд заасан бусад эрхийн нэгэн адил баталгаатай эдлүүлэх үүргийг төр хүлээдэг бөгөөд аль ч эрхийг хязгаарлах боломжтой байдаг ч хүний амь насыг дуусгавар болгох нь “ял шийтгэл” байх явдал эрх зүйт төрд зохимжгүй учир цаазаар авах ялыг халах үндэслэл болдог гэж тайлбарласан. Харин хүний эрүүл мэнд, амь насыг хамгаалах зорилгоор амьд явах эрхийг хязгаарладаг, түүнчлэн бусдыг хамгаалах гарцаагүй шаардлага гарсан, тухайлбал хуулиар цагдаагийн байгууллагын ажилтанд галт зэвсэг хэрэглэхийг зөвшөөрөх нь мөн л амьд явах эрхийн халдлага юм хэмээн жишээ татаж “амьд явах эрхийг гагцхүү Эрүүгийн хуулиар, гагцхүү цаазаар авах ялаар хязгаарлан ойлгох нь хангалтгүй, мөн энэ ялыг халснаар амьд явах эрх огт хөндөгдөхгүй болно гэж үзэх нь өрөөсгөл” гэж дүгнэсэн байдаг. Ийнхүү тэрээр Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг агуулгыг тайлбарлахын сацуу уг агуулгыг боловсронгуй болгож шинээр тодорхойлох хүрээнд үзэл санаагаа илэрхийлсэн гэж хэлж болно.

Тухайлбал, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Аргагүй хамгаалалт”²⁰ нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлийг “зөвшөөрсөн” буюу гэмт хэрэгт тооцохгүй байх зохицуулалт гэдгийг бас харгалзан үзэх ёстой гэж ойлгож байна. Ц.Сарантуяа профессор “Аль ч үндсэн эрхийг хязгааргүй хэрэгждэг, туйлын шинжтэй гэж ойлгох боломжгүй хэмээн Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд үздэгийг хууль тогтоомж боловсруулахдаа харгалзан үзэж уг эрхэд халдах нь огт буруу, эсхүл яаж ч халдсан болно гэсэн хоёр туйлшралаас ангид байхыг

19 Ц.Сарантуяа “Амьд явах эрхийг Үндсэн хуулиар хамгаалах нь”, *Хууль дээдлэх ёс, цуврал 62*, 2017, дугаар 2, 125-132 дахь тал.

20 Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1-д «Өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.» мөн зүйлийн 2-т «Аливаа хүн мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, аюултай довтолгооноос зайлсхийх, бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй.» гэж тус тус зааснаар аргагүй хамгаалалтыг гэмт хэргийг гүйцгэх нөхцөл байдал болгон хуульчилсан.

анхаарах шаардлагатай”²¹ гэж дүгнэснийг мөн анхаарах нь зүйтэй.

Доктор Ч. Нямсүрэн “... олон улсын эрх зүйн баримт бичигт нэгдэхдээ бид олон улсын эрх зүйн хэм хэмжээг өөрийн хууль тогтоомждоо хувиргах(transformation), эсхүл олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх (unification) ёстой. Гэтэл энэ арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйгээс өнөөгийн цаазаар авах ялыг сэргээх, эс сэргээх тухай маргаан нийт ард түмний төдийгүй хуульчдыг хоёр хуваагаад байна.”²² гэсэн байр суурьтай байгаа нь бас цаашид олон улсын гэрээнд нэгдэн орохдоо анхаарах асуудал гэж үзэж байна.

Энэхүү лавлагааны дүнд, эрдэмтэн судлаачид, Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсгийн “... Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэсэн нь цаазаар авах ялыг заавал байлгах агуулгагүй бөгөөд халах үндэслэлийг багтаасан, цаазаар авах ялыг халах талаарх дэлхийн хамтын нийгэмлэгийн чиг хандлагад нийцсэн зохицуулалт гэж үзсэн болохыг тодруулав. Түүнчлэн эрдэмтэн судлаач нар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарлахдаа хүний амьд явах эрхийн агуулгыг өргөн хүрээтэй гэж үзэхээс гадна энэ эрхийг зөвхөн цаазаар авах ял хязгаарладаггүй, зайлшгүй тохиолдолд хүний амьд явах эрхэд халдахыг хуулиар зөвшөөрдөг асуудлыг мөн орхигдуулалгүй, харгалзан үзэхийг зөвлөмжилсөн байна.

21 Ц.Сарантуяа, “Амьд явах эрхийг Үндсэн хуулиар хамгаалах нь”, *Хууль дээдлэх ёс, цуврал 62*, 2017, дугаар 2, 131 дэх тал.

22 Ч.Нямсүрэн, “Монгол Улсад цаазаар авах ялыг хэрэглэх эрх зүйн үндэслэл бий”, (сурв. А.Баярмаа), 2017.12.02, Холбоос: <http://dorgio.mn/p/82729>, Сүүлд үзсэн огноо: 2020.12.02.

ГУРАВ. ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛСАН УЛС ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЦААЗААР АВАХ ЯЛТАЙ ХОЛБООТОЙ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

3.1. Цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын эрх зүйн хөгжлийн тойм

Цаазаар авах ял нь хүний эрхэм байдал, хүний эрх, тэр дундаа хүний амьд явах эрх болон эрүүдэн шүүлт, харгис хэрцгий, хүнлэг бус шийтгэлээс ангид амьдрах эрхийг тус тус зөрчдөг. Эдгээр эрхүүд нь НҮБ-аас 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар хамгаалагддаг.²³ Цаазаар авах ялын талаархи олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарт нь юуны өмнө Хүний эрхийн түгээмэл тунхаглалын хэм хэмжээ бөгөөд түүний 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах ... эрхтэй” гэж заасан байдаг. Эл эрхийг улам тодорхой болгож, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 6 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй. Цаазаар авах ялыг цуцлаагүй улсад уг ялыг зөвхөн онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир энэхүү Пакт болон Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенцийн заалтад нийцсэн бөгөөд тухайн гэмт хэрэг үйлдэх үед хүчинтэй байсан хуулийн дагуу тухайн этгээдэд оногдуулж болно. Энэхүү ялыг эрх бүхий шүүхийн эцсийн шийдвэрийн дагуу гүйцэтгэж болно.” хэмээн заасан байна. Эдгээр хэм хэмжээ нь юуны түрүүнд төрийн зүгээс хүний амь насыг хууль бусаар бусниулж хэрхэвч болохгүй гэсэн утга санааг илэрхийлдэг.

Олон улсын байгууллагаас цаазаар авах ялыг халах тухай дараах баримт бичгийг баталсан байна. Үүнд:

- Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Цаазаар авах ялыг халах зорилготой Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Хоёрдугаар нэмэлт протокол²⁴;
- Европын хүний эрхийн тухай конвенц²⁵-ийн 1982 онд баталсан Цаазаар авах ялыг халах тухай Зургадугаар протокол²⁶;
- Европын хүний эрхийн тухай конвенцийн 2002 онд баталсан Бүх нөхцөлд цаазаар авах ялыг халах тухай Арван гуравдугаар протокол²⁷;
- 1990 оны 06-р сарын 01-ний өдөр баталсан Америкийн Хүний эрхийн тухай конвенцийн Цаазаар авах ялыг халах тухай протокол²⁸ багтана.

Европын холбоо 1950 онд баталсан Европын хүний эрхийн тухай конвенцийн 2 дугаар зүйлд хүний амьд явах эрхийг хамгаалах талаар тусгасан. Үүнд, хууль

23 “Эмнести Интернэшнл байгууллага нь цаазаар авах ялыг бүх тохиолдолд буюу гэмт хэргийн мөн чанар, нөхцөл байдал, хувь хүний гэм буруутай эсэх, цаазаар авах ялыг гүйцэтгэдэг арга хэрэгслээс үл хамааран эсэргүүцдэг.”, About the death penalty, Amnesty international, Холбоос: <https://www.amnesty.org/en/what-we-do/death-penalty/>.

24 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Хоёрдугаар нэмэлт протокол, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/1257>

25 1950 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр гарын үсэг зурахаар нээж, 1953 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

26 The European Convention on Human Rights 1950, Холбоос: https://www.echr.coe.int/documents/convention_eng.pdf

27 Protocol No.13 to the European Convention on Human Rights, concerning the abolition of the death penalty in all circumstances, 2002, Холбоос: https://www.echr.coe.int/Documents/Library_Collection_P13_ET5187E_ENG.pdf.

28 Protocol To The American Convention On Human Rights To Abolish The Death Penalty, Холбоос: <https://www.oas.org/juridico/english/treaties/a-53.html>.

ёсоор цаазаар авах, өөрийгөө хамгаалах, оргон зайлсан сэжигтэн, гэмт этгээдийг баривчлах, үймээн самуун, бослогыг дарах зэрэг тохиолдол үл хамаарна гэж заажээ. Хожим уг конвенцийн 6 дугаар нэмэлт протоколыг баталж, дайны болон үндэсний хэмжээнд онц байдал зарласнаас бусад тохиолдолд цаазаар авах ялыг хориглохыг улс орнуудад уриалсан нь ЕХ-ны бүх улсад хамааралтай. Үүний дараа 2002 онд батлагдсан, тус конвенцийн Бүх нөхцөлд цаазаар авах ялыг халах тухай Арван гуравдугаар протоколд цаазаар авах ялыг бүхэлд нь халах тухай заасныг ЕХ-ны ихэнх гишүүн орнууд хэрэгжүүлж байна.²⁹

1969 онд Америкийн Хүний эрхийн тухай конвенцийг баталсан. Энэхүү конвенц 23 улсад хүчин төгөлдөр үйлчилж байна. Америкийн хүний эрхийн тухай конвенц³⁰-ийн 4.1-д “Хүн бүр амь насаа хүндэтгүүлэх эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаалах бөгөөд, хүүхэд эхийн хэвлийд бүрэлдсэн цагаас эхлэн хамгаална. Хэний ч амь насыг дур зоргоороо бусниулж болохгүй” гэж заажээ.

1966 онд баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт³¹-ын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй.” гэж, мөн 7 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.” гэж тус тус заасан.

ИБУТЭТОУП-ын II Нэмэлт Протокол нь цаазаар авах ялыг халахад чиглэсэн цаазын ялын гүйцэтгэлийг хориглох, цаазын ялыг бүрмөсөн халах тухай дэлхий нийтийг хамарсан цорын ганц олон улсын гэрээ юм. Тус Нэмэлт Протоколд ИБУТЭТОУП-д оролцогч аливаа улс нэгдэн орох нээлттэй. Түүнд нэгдэн орсноор оролцогч улс түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр үндэсний хууль тогтоомждоо ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардалгүйгээр шууд хэрэгждэг онцлогтой. Үүний зэрэгцээ нэгдэн орсон улсад хууль тогтоомжийн хүрээнд цаазын ялыг халах, цаазаар авах ялыг халахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авах үүргийг тус протоколд тусгажээ. Түүнчлэн “цаазаар авах ялыг дахин сэргээх асуудал хөндөгдөх тохиолдолд энэ нь II Нэмэлт Протоколын туйлын зорилгод харш” гэж үзсэн байна.³² Зарим улс уг гэрээнээс татгалзан гарах талаар саналаа илэрхийлсэн боловч мухардалд ороод байна.

Нэмэлт Протоколын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү протоколд дайны үед үйлдсэн хүнд ноцтой цэргийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулж болох тухай түүнийг соёрхон батлах буюу нэгдэн орох үед хийсэн тайлбараас бусад аливаа тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.” гэж заасан. Оролцогч улс тус Протоколд нэгдэн орох үедээ тухайн тайлбарыг хийх эрхтэй бөгөөд нэгдэн орсноос хойш тайлбар хийх боломжгүй болдог. Энэхүү олон улсын гэрээ нь буцаж гарах заалт агуулаагүй бөгөөд энэ төрлийн олон улсын гэрээнээс буцаж гарах боломжгүй болохыг Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцийн холбогдох заалт болон НҮБ-ын

29 The [European Convention on Human Rights](#) 1950.

30 The American Convention on Human Rights, 1969.

31 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966 он, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/1257>

32 UN Doc E/CN.4/Sub.2/1987/20, 162.

Хүний эрхийн хорооны 26 дугаар Ерөнхий зөвлөмжөөр зохицуулсан болно.³³

3.2. Цаазаар авах ялаас татгалзаж буй дэлхийн улс орнуудын хандлага

Цаазаар авах ялын талаарх гадаад орнуудын ерөнхий мэдээлэл болон цаазаар авах ялтай холбоотой эрх зүйн асуудлын тухайд, Roger Hood & Carolyn Hoyle, *The Death Penalty: A Worldwide Perspective* (OUP 4th edition 2008) сэдэвт судалгаа өндөр ач холбогдолтойд тооцогдож байна. Тухайлбал тус судалгааны 9 дүгээр бүлэг буюу Цаазаар авах ял гэмт хэргийн гаралтыг багасгадаг уу, үгүй юу гэсэн асуудалд эмпирик түвшинд шинжилгээ хийсний үр дүнд гэмт хэрэг гаралтыг бууруулах зорилгоор цаазын ялыг сэргээх ёстой гэж үзэх нь үндэслэлгүй болохыг харуулжээ. Энэ дүгнэлт улс орнууд цаазаар авах ялтай холбоотой хууль зүйн бодлогоо тодорхойлоход дэмжлэг үзүүлж байна.

1988 оны сүүлчээс цаазаар авах ялыг халах улс орнуудын тоо эрс нэмэгджээ. Цаазаар авах ял нь хүний амьд явах үндсэн эрхийн эсрэг бөгөөд эрүү шүүлт, харгис хэрцгий, хүнлэг бус шийтгэлээс ангид байх эрхийг үгүйсгэсэн гэх “шинэ давлагаа” бий болсон. Цаазаар авах ялыг халахыг бүх нийтийн зорилт болгон тусгасан хүний эрхийн олон улсын гэрээ болон түүний хэрэгжилтийг хариуцагч, дэмжигч байгууллагууд бий болон хөгжсөөр ирсэн. Цаазаар авах ялыг хуулиар албан ёсоор халаагүй тохиолдолд цаазаар авах ялыг ямар хэмжээнд, ямар арга замаар хязгаарласан бэ гэдгийг бас чухалчилдаг. Түүнчлэн дэлхий дахинаа цаазаар авах ялыг хэрэглэдэг улс орнууд ч цаашид уг ялыг аажмаар бууруулах, эцэслэн халах хэтийн төлөвийг судалж байна. Цаазаар авах ялыг хуулийн дагуу, зохистой хэрэглэх, гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хүчирхийлэл дор, хилсээр цаазаар авах ял авахаас хамгаалах хүрээнд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой гэдгийг улс орнууд улам бүр хүлээн зөвшөөрсөөр байна.³⁴

Сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар гурваас доошгүй улс цаазын ялыг халж, хүний амь нас, нэр төрд хүндэтгэлтэй ханддагаа баталжээ.³⁵ Маш олон засгийн газар цөөн хэдэн, эсвэл бүр хэдэн зуун хоригдлыг цаазлах замаар нийгэм, улс төрийн тулгамдсан асуудлаа шийдэж чадна гэдэгт итгэдэг хэвээр байна. Олон орны иргэд цаазаар авах ял нийгмийг цаашид хамгаалах бус харин ч илүү харгис болгож байгааг мэдэхгүй хэвээр байна³⁶ гэж Amnesty international байгууллага онцолж байв.

Улс орны нийт хүн амын нэрийн өмнөөс гүйцэтгэдэг ял гэдэг утгаараа цаазаар авах ялын асуудал хүн бүрийг хамардаг гэж хэлж болно. Цаазын ял гэж юу болох, хэрхэн хэрэглэх, хүмүүст хэрхэн нөлөөлөх тухай болон хүний үндсэн эрхэд халдах асуудал гэдгийг хүн бүр мэддэг байх ёстой. Цаазаар авах ял нь хүний амь насыг төрөөс санаатайгаар, хүйтэн цуст аллага үйлдэж хөнөөдөг хэрэг юм. Иймээс

33 Г.Агар-Эрдэнэ, “Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоос оролцогч улсбуцаж гарах боломжтой юу?”, “*Үндсэн хууль ба цаазаар авах ял*” хэлэлцүүлгийн эмхтгэл, (УБ, 2018), 47-55 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.

34 Abolishing the Death Penalty Worldwide: The Impact of a “New Dynamic”, Crime and justice g review of research. Michael Tonry, 2009.

35 Сүүлийн 10 жилд цаазаар авах ялыг бүхэлд нь халсан улсууд бол Албани, Армени, Азербайжан, Бутан, Босни Герцеговина, Болгар, Канад, Кот-д’Ивуар, Кипр, Зүүн Тимор, Эстони, Гүрж, Грек, Либерти, Литва, Мальта, Мексик, Монтенегро, Балба, Польш, Филиппин, Руанда, Самоа, Сенегал, Серби, Өмнөд Африк, Турк, Туркменистан, Украин, Их Британи юм. Чили, Боливи, Латви, Киргиз улсууд ердийн гэмт хэрэгт цаазын ялыг халсан.

36 The death penalty v. human rights, Amnesty international, 2007.


цаазаар авах ялын эсрэг үзэл санааны гол цөм нь төрд ийм эрх бий юу гэдэг асуудал юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний үндсэн эрхийн суурь болох эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг сурталчлахыг нийт үндэстнүүдэд уриалдаг. Түүний тунхаглаж буй эрх нь хүн бүрийн төрөлх эрх юм. Эдгээр эрх нь сайн зан үйлийн төлөө засгийн газраас иргэдэд олгодог давуу эрх биш бөгөөд муу зан авир гаргасан тохиолдолд эргүүлэн авах боломжгүй язгуур эрх юм.

2021 оны эцсийн байдлаар, дэлхийн улс орнуудын гуравны хоёроос илүү нь цаазаар авах ялыг хуульдаа болон практикт халаад байна. 108 улс буюу дэлхийн дийлэнх улсад бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг хуулиар, 144 улс цаазаар авах ялыг хуулиар болон практикт хэрэгжүүлж халсан бөгөөд 55 улс цаазаар авах ялыг хэвээр хадгалсаар байгаа хэдий ч нэлээд хэд хэдэн улсад нэг жилд гүйцэтгэх тоо нь буурсан үзүүлэлт ажиглагдаж байна.³⁷ Үүнээс харахад, цаазаар авах ялыг халах үзэл баримтлалыг үл харгалзан цөөн тооны улс орнуудад цаазаар авах ялыг хэрэглэсээр байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг гэсэн нотлогдоогүй домогтой холбоотой гэж үздэг.³⁸ Цөөн хэдэн муж, улсууд хүнийг санаатай алахаас бусад гэмт хэрэгт, тэр дундаа хар тамхитай холбоотой гэмт хэрэг, терроризмын гэмт хэрэгт цаазаар авах ялыг хэрэглэхийг зөвшөөрсөн хэвээр байна.³⁹ Хүний эрхэм байдлыг дээшлүүлж, хүний эрхийг хөгжүүлэхийн тулд дэлхий даяар цаазаар авах ялыг халах шаардлагатай гэж ихэнх судлаач үзэж байна.

Түүнчлэн НҮБ болон бүс нутгийн байгууллагууд, хүний эрхийн иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд, олон орны хуульчдын холбоо, судалгааны төвүүд, 150 орчим орны судлаач, мэргэжилтнүүд оролцож боловсруулсан “Эрүүгийн загвар хууль”-ийн ялын төрөлд цаазаар авах ялыг оруулаагүй нь уг ялыг халах дэлхий нийтийн чиг хандлагыг илэрхийлдэг.⁴⁰

График 6.1. Цаазаар авах ялаас татгалзаж буй хандлага



37 Death penalty 2021: Facts and figures. Amnesty international, 2022, Холбоос: <https://www.amnesty.org/en/latest/news/2022/05/death-penalty-2021-facts-and-figures/>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.22.

38 United Nations, Death Penalty, Холбоос: <https://www.ohchr.org/en/topic/death-penalty>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.22.

39 Death penalty 2021: Facts and figures. Amnesty international, 2022, Холбоос: <https://www.amnesty.org/en/latest/news/2022/05/death-penalty-2021-facts-and-figures/>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.22.

40 Vivienne O'Connor and Colette Raus, Model Codes for Post-Conflict Criminal Justice: Volume 1: Model Criminal Code (Peacebuilding and the Rule of Law, 2007), pg110, Сүүлд үзсэн огноо: 2022.06.21.

3.3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт II протоколд нэгдэж цаазаар авах ялыг халсан улс орнуудын Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтын онцлог

2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар, цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд 90 улс нэгдсэн байна. Эдгээр орнууд дотоодын хууль тогтоомжоо тус олон улсын гэрээнд нийцүүлэх үүрэг хүлээсэн. Монгол Улс 2015 онд Эрүүгийн хуульдаа цаазаар авах ялыг тусгалгүй халж олон улсын гэрээний үүргээ эрх зүйн хүрээнд биелүүлсэн. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1. “амьд явах эрхтэй. Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно” гэсэн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх хүрээнд тухайлсан дүгнэлт одоогоор хэвлэн нийтлэгдээгүй байна. Энэ асуудалд судалгаагаар дэмжлэг үзүүлэх зорилгоор, цаазаар авах ялын тухайд манай улстай эрх зүйн хөгжлийн ижил түвшинд байгаа буюу Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдсэн улс орнуудын Үндсэн хууль болон Эрүүгийн хууль дахь цаазын ялтай холбоотой хэм хэмжээг түүвэрлэн лавлагаа (Хавсралт 2-оос дэлгэрүүлж үзнэ үү) боловсрууллаа. Тэдгээр улс орнуудаас тус протоколд нэгдэн орохдоо “тайлбартай нэгдэн орсон” улсын хувьд Эрүүгийн хуульд нь цаазын ялтай холбоотой зохицуулалт байв. “Тайлбаргүй” буюу шууд нэгдэн орсон улсуудын Эрүүгийн хуульд цаазын ялтай холбоотой заалт байхгүй гэсэн нийтлэг байдал илэрсэн. Энэхүү лавлагааны Үндсэн хуулийн хэм хэмжээтэй холбогдох хэсэгт дүн шинжилгээ хийж үзье.

Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдсэн нийт 90 улсаас Үндсэн хуульгүй 2 улс⁴¹-аас бусад 87 улс (Монгол Улсаас бусад)-ын Үндсэн хуулийн цаазын ялтай холбоотой хэм хэмжээг түүвэрлэн төсөөтэй байдлаар нь бүлэглэн авч үзвэл дараах онцлог ажиглагдаж байна.

“Цаазаар авах ял оногдуулахгүй”, “цаазаар авах ялыг хориглосон” гэсэн утга агуулгыг ҮХ-даа тусгасан нийт 27 улс, жишээлбэл Андорра, Аргентин, Румын, Серби, Швед, Швейцарь, Уругвай улс орно. Тухайлбал, Бүгд Найрамдах Ангол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд “Цаазаар авах ялыг хориглоно”⁴², Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3-т “Цаазаар авах ялыг хориглоно” гэж тус тус заажээ.

“Цаазаар авах ялыг халав” гэсэн утга агуулгыг үндсэн хуульдаа тусгасан нийт 5 улс, эдгээр нь Австри, Герман, Бельги, Монако, Парагвай улс юм. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн 102 дугаар зүйлд “Цаазаар авах ялыг халсан”⁴³, Австри улсын Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд: «Цаазын ялыг халсан»

41 ИБУИНВУ, Шинэ Зеланд улсын тухайд бичигдмэл Үндсэн хууль байдаггүй тул Үндсэн хуулийн цаазаар авах ялын зохицуулалтын тухай ярих боломжгүй. Эдгээр улсын хувьд холбогдох бусад хуулиудаар цаазаар авах ялыг халсан. Тухайлбал, ИБУИНВУ 1998 онд Цаазаар авах ялыг бүр мөсөн халах тухай хууль баталсан.

42 Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Angola_2010.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

43 Basic Law for the Federal Republic of Germany in the revised version published in the Federal Law Gazette Part III, classification number 100-1, as last amended by Article 1 of the Act of 29 September 2020 (Federal Law Gazette I p. 2048).

гэж тус тус заасан.⁴⁴

“Ямар ч тохиолдолд цаазаар авах ялыг хориглоно”, “Хуулийн хүрээнд, шүүхийн практикт... цаазаар авах ялыг хориглоно” гэх мэтчилэн бүх талаар хориглосон тухай дэлгэрэнгүй утга агуулгыг ҮХ-даа тусгасан 8 улс, тухайлбал Панам, Португал, Сейшелийн Арлуудын Бүгд Найрамдах Улс үүнд орно. Бүгд Найрамдах Панам улсын Үндсэн хуулийн 30-р зүйл. “Цаазаар авах ял аливаа хэлбэрээр байхгүй”, Сейшелийн Арлуудын Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуульд “Аль ч шүүхэд цаазаар авах ял оногдуулах эрхийг хуулиар олгохгүй” гэж тус тус заасан.⁴⁵ Намиби улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн «Хүний үндсэн эрх, эрх чөлөө» гэсэн 3-р бүлэгт: «Амьд явах эрхийг хүндэтгэж, хамгаална. Ямар ч хуульд цаазаар авах ялыг хуульчилж болохгүй. Ямар ч шүүх хэнд ч цаазаар авах ял оногдуулах эрхгүй. Намиби улсад цаазаар авах ялыг гүйцэтгэх ёсгүй».⁴⁶ гэж заасан нь онцлог юм.

“... улс цаазаар авах ялгүй” “... улсад цаазаар авах ял байхгүй”, “цаазаар авах ял байх ёсгүй” гэсэн утга агуулгыг ҮХ-даа тусгасан нийт 11 улс, тухайлбал Колумби, Боливи, Хорват, Эквадор, Ирланд, Непал улс орно. Колумби Улсын Үндсэн Хуулийн 11 дүгээр зүйлд “Цаазаар авах ял байх ёсгүй.”⁴⁷, Эквадор улсын Үндсэн хуулийн 66.1-д “Цаазаар авах ял байх ёсгүй.”⁴⁸ гэж тус тус заажээ.

“...- аас бусад тохиолдолд цаазаар авахыг хориглоно” буюу цаазаар авах ялыг хэрэглэх нөхцөл заасан тайлбар бүхий утга агуулгыг тусгасан нийт 9 улс байна. Тухайлбал, Грек, Испани, Чили, Кипр улс орно. Испанийн Үндсэн хуульд “Хүн бүр амьд явах, бие махбодийн болон ёс суртахууны хувьд бүрэн бүтэн байх эрхтэй бөгөөд ямар ч тохиолдолд эрүүдэн шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг гутаасан шийтгэл оногдуулж, ийм байдлаар харьцаж болохгүй. Дайны үеийн цэргийн эрүүгийн хуулиар тогтоосон тохиолдлоос бусад тохиолдолд цаазаар авах ялыг цуцална.”⁴⁹, Бүгд Найрамдах Чили Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1. “Цаазаар авах ялыг зөвхөн бүрэн эрхт чуулганаас баталсан хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулж болно”⁵⁰, 9 дүгээр зүйл “Терроризмын гэмт хэрэг үйлдсэн хүнд цаазаар авах ялыг бүх насаар нь хорих ял болгон өөрчлөхөөс бусад тохиолдолд өршөөл үзүүлэхгүй.”⁵¹, Бүгд Найрамдах Кипр Улсын Үндсэн Хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “Хуульд ийм шийтгэл оногдуулсан гэм буруутайд тооцсон хүчин төгөлдөр шүүхийн шийтгэл тогтоол биелүүлэхээс бусад тохиолдолд хэний ч амь насыг бүрэлгэж болохгүй. Зөвхөн санаатай аллага үйлдэх, эх орноосоо урвах, далайн дээрэм, цэргийн хуулийн дагуу цаазын ялтай гэмт хэрэг үйлдсэн

44 Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Austria_2009.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

45 Seychelles's Constitution of 1993 with Amendments through 2017, Chapter III, 15.1, 15.2, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Seychelles_2017.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

46 Constitutional prohibitions of the death penalty, Constitution of the Republic of Namibia (1990), Холбоос: <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2021/06/act500061996en.pdf>. Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

47 Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Colombia_2015.pdf?lang=en. Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

48 Холбоос: <https://pdba.georgetown.edu/Constitutions/Ecuador/english08.html>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

49 The Spanish Constitution, Article 15, Холбоос: <https://www.boe.es/legislacion/documentos/ConstitucionINGLES.pdf>.

50 Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Chile_2015.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

51 Мөн тэнд.

тохиолдолд л ийм шийтгэлийг хуулиар тогтоож болно.” Бүгд Найрамдах Грек Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд “Эд хөрөнгийг ерөнхийд нь хураахыг хориглоно. Дайны үеийн гэмт хэрэг болон хуульд заасан хүнд гэмт хэргээс бусад гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулж болохгүй”⁵² гэж тус тус заажээ.

Цаазаар авах ялын талаар тухайлсан бичвэр байхгүй буюу “амьд явах эрх халдашгүй” гэсэн утга агуулгыг тусгах байдлаар хүний амьд явах эрхийн агуулгыг багтаасан нийт 27 улс, тухайлбал Албани, Канад, Коста Рика, Гамби, Эстон, Польш, Финланд, ӨАБНУ улс үүнд орно. Албани улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд “Хүний амьд явах эрх хуулиар хамгаалагдана” гэж заасан бөгөөд цаазаар авах ялтай холбоотой заалт байхгүй байна.⁵³ ӨАБНУ-ын Үндсэн хуульд “Хүн бүр амьд явах эрхтэй.”⁵⁴ Бүгд Найрамдах Коста Рика Улсын Үндсэн Хуулийн 21 дүгээр зүйлд “Хүний амь нас халдашгүй байна” Финландын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 7-р хэсэгт “Хүн бүр амьд явах, хувийн эрх чөлөө нь бүрэн бүтэн байх, аюулгүй байх эрхтэй”⁵⁵ гэж тус тус заажээ.

Амьд явах эрх халдашгүй байх талаар тусгахаас гадна энэ эрхэд халдаж болох бусад тохиолдол(цаазаар авах ялаас бусад)-ыг тусгасан зохицуулалт бүхий улс (Мадагаскар, Мальта улсын жишээ) бас байна. Мадагаскар улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйл. “Хүн бүрийн амьд явах эрхийг хуулиар хамгаална. Хэн ч дур зоргоороо хүний амь насанд халдаж болохгүй. Бүх хүнийг хууль бус хүчирхийллээс хамгаалах үүднээс зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэсний улмаас хүнийг үхэлд хүргэсэн тохиолдлыг энэ зүйлд заасныг зөрчсөнд тооцохгүй.”⁵⁶ Мальта улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-д “Эрүүгийн гэмт хэрэгт шүүхээс ял оногдуулснаас бусад тохиолдолд санаатайгаар хүний амь насыг бусниулж болохгүй”, мөн зүйлийн 2-т “Дараах тохиолдолд хууль зөрчихгүйгээр хүч хэрэглэсний улмаас хүний амь насанд халдвал энэ зүйлд заасныг зөрчсөнд тооцохгүй: а. аливаа хүнийг хүчирхийллээс хамгаалах, өмч хөрөнгийг хамгаалах зорилгоор; б. хууль ёсны дагуу баривчлах, эсхүл хууль ёсоор баривчлагдсан этгээдийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор; в. үймээн самуун, бослогыг дарах зорилгоор; г. тухайн этгээдийг эрүүгийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл дайны ажиллагааны улмаас нас барсан тохиолдол.”⁵⁷ гэж тус тус заажээ.

Лавлагаанд хамрагдсан 87 улсын Үндсэн хуулийн хэм хэмжээг харьцуулж дүгнэхэд:

1. Цаазаар авах ялыг заавал оногдуулах тухай утга агуулга бүхий заалт байхгүй байна;

52 Greece’s Constitution of 1975 with Amendments through 2008, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Greece_2008.pdf?lang=en , Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

53 Холбоос: [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2016\)064-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2016)064-e), Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

54 The Constitution of the republic of south africa, 1996, Chapter 2, Article 11, Холбоос: <https://dearsouthafrica.co.za/wp-content/uploads/2018/05/SACConstitution-web-eng.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

55 Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Finland_2011.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

56 Madagascar’s Constitution of 2010, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Madagascar_2010.pdf?lang=en , Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

57 Malta’s Constitution of 1964 with Amendments through 2016, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Malta_2016.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

2. Хүний амьд явах эрх халдашгүй байх тухай заалтын агуулгад багтааж цаазаар авах ялын талаар огт тусгаагүй, эсхүл “амьд явах эрхтэй”, “амьд явах эрх халдашгүй байна” гэсний дараа “цаазын ялыг хориглосон”, “цаазын ялыг халсан” гэсэн утга агуулга нэмсэн бичиглэл, техникийн хэлбэрүүд түгээмэл байна;
3. “...-аас бусад тохиолдолд цаазаар авах ялыг хориглоно” гэсэн нь Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд тайлбартайгаар нэгдсэн буюу тухайн гэрээнд нэгдэхдээ ямар тохиолдолд уг ялыг хэрэглэх тухайгаа илэрхийлсэн болохыг ҮХ-даа тусгасан байх магадлалтай.⁵⁸;
4. Цаазаар авах ялыг хориглосон, цаазаар авах ялгүй гэдгээ илэрхийлсэн утга агуулга бүхий товч бичвэр нэлээд олон байгаа бол эрх зүйн хүрээнд болон шүүхийн практикт гэх мэтчилэн уг ялыг бүх талаар хориглосон утга агуулга бүхий дэлгэрэнгүй бичиглэл, техникийн хэлбэр цөөн тоотой байдал ажиглагдав;
5. Амьд явах эрхийн талаар тусгахдаа, энэ эрхэд халдаж болох бусад тохиолдлууд(цаазаар авах ялаас бусад)-ыг дурдаж хуульчилсан хэлбэр бас багтаж байна;
6. Улс орнуудын Үндсэн хууль дахь цаазаар авах ялтай холбоотой зохицуулалтууд ерөнхийдөө, “хүн амьд явах эрхтэй” гэсэн заалт нь өөрөө цаазаар авах ялын эсрэг агуулгыг давхар агуулсан хэмээн тайлбарлаж, Үндсэн хуульд цаазаар авах ялын талаар нэмэлт тодотгол оруулах шаардлагагүй гэж үзсэн, эсхүл амьд явах эрхтэй холбоотой зохицуулалтыг тусгахдаа “цаазаар авахыг хориглох тухай” заалтыг нэмэлтээр оруулсан хэлбэр болон түүнтэй төсөөтэй хувилбаруудын олон янз байдал ажиглагдаж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, олон улсын эрх зүйн хөгжлийн нөлөөгөөр Монгол Улсад хүний эрхийн хамгааллын тогтолцоо сайжирч байна. Монгол Улс 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколыг соёрхон баталж, улмаар 2015 онд Эрүүгийн хуульдаа уг ялыг тусгалгүй халсан. Ингэснээр цаазаар авах ялыг хэрэглэж, халсан хэрнээ сэргээж байсан эрх зүйн түүх Монгол Улсын хувьд ард үлдэж цаазаар авах ялгүй орон болов. Энэхүү үйл хэрэг Үндсэн хуулийн дагуу өрнөсөн бөгөөд түүнд заасан хүний эрхэм байдал, хүний амьд явах эрх зэрэг бүхий л эрхийг баталгаатай эдлүүлэх тал дээр томоохон дэвшил гарсан.

Цаазаар авах ялыг халсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар даяар олноо зарлан тунхагласан Монголын ард түмний эрхэм зорилго, үзэл баримтлал, агуулга, үнэт зүйлтэй бүрэн нийцсэн. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын гэрээнд нэгдсэн гэсэн үг юм. Цаазаар авах ялыг халахдаа, дэлхий нийтээр уг ялыг халах нь зүйтэй гэж уриалахад хүргэсэн үзэл санаа болох цаазаар явах ял нь буцаах боломжгүй бөгөөд алдаа гарвал засах аргагүй үйлдэл; гэмт хэргийн гаралтыг бууруулахгүй; ихэвчлэн буруу шүүхийн тогтолцоонд ашиглагддаг; ялгаварлан гадуурхах шинжтэй; уг ялыг улс төрийн хэрэгсэл болгож ашигладаг гэсэн үндэслэлүүдийг харгалзсан.

58 Энэхүү судалгааны хүрээнд тухайн улс орны гэрээнд нэгдэхдээ хийсэн тайлбар буюу гэрээгээр хүлээсэн үүргийн хэм хэмжээ ба Үндсэн хуулийн нийцлийн талаар тодруулахыг зориогүй болно.

Цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын гэрээнд нэгдсэн явдал Үндсэн хууль зөрчөөгүй; Олон улсын эрх зүйн онол, зарчмын хувьд, цаазаар авах ялыг сэргээн хэрэглэх хэрэгцээ, шаардлага байхгүй бөгөөд эрх зүйн хувьд Цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын гэрээнээс татгалзан гарах, цуцлах боломжгүй. Харин ч цаазаар авах ялыг сэргээх асуудал нь олон улсын эрх зүйн төдийгүй үндэсний эрх зүйн, тухайлбал Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил үүсгэнэ. Цаазаар авах ялыг сэргээвэл Үндсэн хууль зөрчинө. Үндсэн хуульд заасан хүний бүх эрхийг үгүйсгэнэ гэсэн судлаачдын дүгнэлтүүд нэгдмэл байр суурийг илэрхийлжээ.

Монгол Улс, цаазаар авах ялын тухайд өнөөгийн хүрсэн хөгжлийн төвшин, байр суурь, амжилтаасаа ухрах ёсгүй гэдэг дүгнэлтийг хийхдээ цаазаар авах ял судлалын түүхэн хөгжил, үр нөлөөнд суурилан, уг ялаас татгалзаж буй олон улсын чиг хандлагад тулгуурлан, цаазаар авах ялыг халсан эрх зүйн үндэслэлийг олон улсын эрх зүйн ба Үндсэн хуулийн эрх зүйн онолын төвшинд судлаачид тайлбарласныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно" гэсэн нь цаазаар авах ялыг заавал байлгах агуулгагүй бөгөөд халах үндэслэлийг багтаасан, цаазаар авах ялыг халах талаарх дэлхийн хамтын нийгэмлэгийн чиг хандлагад нийцсэн зохицуулалт юм гэсэн тайлбарыг нэлээд хэдэн эрдэмтэн судлаач хийсэн байна. Харин эдгээр онолын үндэслэлтэй дүгнэлт бүхий тайлбарыг иргэдэд түгээж, ухуулан таниулах замаар иргэдийн эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Цаазаар авах ялыг халсантай холбогдуулан Үндсэн хуулийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх асуудлаар дүгнэлт хийж, санал гаргасан байдал одоогоор хэвлэн нийтлэгдээгүй байна. Энэхүү судалгааны хэрэгцээ, шаардлагад үндэслэн, ХЗДХЯ-аас ирүүлсэн захиалгын дагуу, цаазаар авах ялтай холбоотой эрх зүйн хүрээний зарим асуудлыг нэгтгэн дүгнэж, гадаад орнуудын чиг хандлагыг шинжлэн судалсны үндсэн дээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулах ажлын хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхэд зориулж лавлагаа мэдээлэл, санал, зөвлөмж боловсруулав.

Энэ хүрээнд:

1. Цаазаар авах ялтай холбоотой судалгааны эх сурвалжийн лавлагаа бэлтгэв;
2. Монгол Улс цаазаар авах ялыг халсны дараа үүссэн эрх зүйн хүрээний зарим асуудлыг нэгтгэн дүгнэж лавлагаа бэлтгэв;
3. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн тухай зарим судлаачдын тайлбарыг нэгтгэн дүгнэж, лавлагаа бэлтгэв;
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдсэн орнуудын Үндсэн хууль дахь цаазаар авах ялтай холбоотой хэм хэмжээний тухай лавлагаа бэлтгэж, түүний үндсэн дээр харьцуулан шинжлэв.
5. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулах чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээний санал, зөвлөмж дэвшүүлэв.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Санал

Цаашид хууль зүйн бодлогын хүрээнд, 1. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг зөвлөлдөж тодруулах; 2. Хэрэв шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, ямар агуулгаар хэрхэн тусгах тухайд, энэхүү судалгаанд тусгагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдсэн улс орнуудын Үндсэн хууль дахь холбогдох хэм хэмжээний нийтлэг жишгийг харгалзан үзсэний үндсэн дээр үндэсний онцлогт тохирсон хувилбарыг боловсруулах нь зүйтэй гэсэн ерөнхий саналыг дэвшүүлж байна.

Зөвлөмж

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд тус судалгаанд багтсан мэдээлэл, лавлагаа, судалгаа шинжилгээний дүгнэлтүүд дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж, дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодруулах хүрээнд дараах чиглэлээр ажиллах нь зүйтэй. Үүнд:

- Цаазаар авах ялыг халсантай холбоотой үүссэн эрх зүйн асуудалд дүгнэлт хийсэн судалгааны ажлын үр дүн, түүний дотор Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт хийсэн судлаачдын тайлбар, санал, зөвлөмжийг харгалзан үзэх;
- Ярилцлагын зэрэг судалгааны арга хэлбэрээр, мэргэшсэн судлаач эрдэмтдийн саналыг авч тусгах, тухайлбал судалгааны чиглэл, судалгааны бүтээл хэвлүүлсэн байдлыг харгалзан, эрдэмтэн судлаач Ц.Сарантуяа, Д.Лүндээжанцан, С.Нарангэрэл, Ж.Амарсанаа, Д.Солонго, Б.Амарбаясгалан, О.Мөнхсайхан, Д.Баярсайхан, Р.Мухийт, Г.Оюунболд, Р.Очирбал, Агар-Эрдэнэ зэрэг судлаачдыг төлөөлөл болгон оролцуулах;
- ҮндХЦ, ХЭҮК, МХХ-ны Үндсэн хуулийн эрх зүйн хороо, Олон улсын эрх зүйн хороо, МӨХ, хууль зүйн их, дээд сургуулиуд, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг судалгааны байгууллага болон Монголын Эмнести Интернешнл байгууллага, Нээлттэй нийгэм форум зэрэг хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагууд зэрэг тал бүрийн оролцоог бүрдүүлж, хэлэлцэх, зөвлөлдөх ажиллагааг хэрэгжүүлэх.

2. Гадаад улсуудын Үндсэн хууль дахь холбогдох хэм хэмжээний талаарх нийтлэг жишиг, сайн туршлагыг харгалзах хүрээнд энэхүү судалгааны 3 дугаар бүлгийн “Цаазаар авах ялыг халсан улс орнуудын Үндсэн хууль дахь цаазаар авах ялтай холбоотой хэм хэмжээ -харьцуулсан шинжилгээ” хэсэг дэх 2 бүлэг дүгнэлтийг ашиглах. (Мөн энэхүү судалгааны хавсралт- 2 хэсгийн лавлагаанаас дэлгэрүүлж үзэх боломжтой.)

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарлахдаа хүний амьд явах эрхийн агуулгыг өргөн хүрээтэй гэж үзсэнээс гадна энэ эрхийг зөвхөн цаазаар авах ял хязгаарладаггүй, зайлшгүй тохиолдолд хүний амьд явах эрхэд халдахыг хуулиар зөвшөөрдөг асуудлыг мөн орхигдуулалгүй харгалзан үзэхийг зөвлөмжилсөн эрдэмтэн судлаачдын санал, зөвлөмжийг харгалзан үзэх.

Цаашид бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд:

- Цаазаар авах ялыг халахад чиглэсэн олон улсын гэрээнд нэгдэж уг ялыг халсны ач холбогдол хийгээд цаашид энэ гэрээнээс гарах эрхгүй, зөвхөн үүрэг хүлээгч болсон гэдгийг иргэдэд ухуулан таниулсан эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа хийх;
- Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал, Үндсэн хуулийн эрх зүйн олон улсын гэрээний үзэл баримтлал болон Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколын талаар эрх зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгаа хийх ажлыг тусгах шаардлагатай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протоколд нэгдсэн 90 улсын Үндсэн хууль
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протоколд нэгдсэн улсуудын Эрүүгийн хууль
4. Монгол Улсын Эрүүгийн хууль
5. Хууль тогтоомжийн тухай хууль

Олон улсын гэрээ:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
2. Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пакт
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протокол
4. Европын хүний эрхийн тухай конвенцийн 1982 онд баталсан Цаазаар авах ялыг халах тухай Зургадугаар протокол
5. Европын хүний эрхийн тухай конвенцийн 2002 онд баталсан Бүх нөхцөлд цаазаар авах ялыг халах тухай Арван гуравдугаар протокол
6. Америкийн Хүний эрхийн тухай конвенцийн Цаазаар авах ялыг халах тухай протокол
7. Гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенц
8. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 26 дугаар Ерөнхий зөвлөмж

Дотоод эх сурвалж:

1. Цаазаар авах ялтай холбоотой зарим эх сурвалжийн лавлагааны жагсаалт Хавсралт 1- д багтсан эх сурвалжууд
2. Б.Амарбаясгалан, Цаазаар авах ял: эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал (УБ: МУИС, Хууль зүйн сургууль, 2015)
3. Г.Совд, “Арван зургадугаар зүйл,” Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000
4. Д.Солонго, “Арван зургаадугаар зүйлийн 1, 2, 5, 6 дахь заалт,” Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (УБ: Ханнс Зайделийн сан, 2009)
5. Ц.Сарантуяа “Амьд явах эрхийг Үндсэн хуулиар хамгаалах нь”, Хууль дээдлэх ёс, цуврал 62, 2017, дугаар 2, 125-132 дахь тал
6. О.Мөнхсайхан, “Цаазаар авах ялыг сэргээвэл олон улсын хууль төдийгүй үндсэн хууль зөрчинө”, “Үндсэн хууль ба цаазаар авах ял” хэлэлцүүлгийн эмхтгэл, 13-40 дэх тал
7. Р.Очирбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орох тухай Монгол улсын хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаарх маргаантай холбогдуулан гаргасан Монголын Эмнести Интернэшнл байгууллагын байр суурь, тайлбар, мэдээлэл, «Үндсэн хууль ба цаазаар авах ял» хэлэлцүүлгийн эмхтгэл, 3-11 дэх тал
8. “Үндсэн хууль ба цаазаар авах ял” хэлэлцүүлгийн эмхтгэл, Монголын Эмнести Интернэшнл байгууллага, 2018

9. Г.Оюунболд, “Онц ноцтой гэмт хэргийн гаралт, түүнд нөлөөлөх хүчин зүйл”, «Үндсэн хууль ба цаазаар авах ял» хэлэлцүүлгийн эмхтгэл, 41-46 дахь тал үү. https://www.academia.edu/37810480/ҮНДСЭН_ХУУЛЬ_БА_ЦААЗААР_АВАХ_ЯЛ
10. Г.Агар-Эрдэнэ, “Цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколоос оролцогч улс буцаж гарах боломжтой юу?”, «Үндсэн хууль ба цаазаар авах ял» хэлэлцүүлгийн эмхтгэл, 47-55 дахь тал https://www.academia.edu/37810480/ҮНДСЭН_ХУУЛЬ_БА_ЦААЗААР_АВАХ_ЯЛ

Гадаад эх сурвалж:

1. Abolishing the Death Penalty Worldwide: The Impact of a “New Dynamic”, Crime and justice g review of research. Michael Tonry, 2009.
2. Vivienne O’Connor and Colette Raus, Model Codes for Post-Conflict Criminal Justice: Volume 1: Model Criminal Code (Peacebuilding and the Rule of Law, 2007)
3. About the death penalty, Amnesty international. <https://www.amnesty.org/en/what-we-do/death-penalty/>
4. The European Convention on Human Rights 1950. https://www.echr.coe.int/documents/convention_eng.pdf
5. Protocol No. 13 to the European Convention on Human Rights, concerning the abolition of the death penalty in all circumstances, 2002. https://www.echr.coe.int/Documents/Library_Collection_P13_ET187E_ENG.pdf
6. Protocol To The American Convention On Human Rights
7. To Abolish The Death Penalty <https://www.oas.org/juridico/english/treaties/a-53.html>
8. The European Convention on Human Rights 1950.
9. UN Doc E/CN.4/Sub.2/1987/20. 162
10. The death penalty v. human rights, Amnesty international. 2007.
11. Death penalty 2021: Facts and figures. Amnesty international, 2022. <https://www.amnesty.org/en/latest/news/2022/05/death-penalty-2021-facts-and-figures/>
12. United Nations, Death Penalty. <https://www.ohchr.org/en/topic/death-penalty>
13. Death penalty 2021: Facts and figures. Amnesty international, 2022. Сүүлд үзсэн:2022.06.22 <https://www.amnesty.org/en/latest/news/2022/05/death-penalty-2021-facts-and-figures/> <https://www.amnesty.org/en/what-we-do/death-penalty/>
14. https://www.constituteproject.org/constitution/Angola_2010.pdf?lang=en
15. Basic Law for the Federal Republic of Germany in the revised version published in the Federal Law Gazette Part III, classification number 100-1, as last amended by Article 1 of the Act of 29 September 2020 (Federal Law Gazette I p. 2048).
16. https://www.constituteproject.org/constitution/Austria_2009.pdf
17. Seychelles’s Constitution of 1993 with Amendments through 2017, Chapter III, 15.1, 15.2, [tps://www.constituteproject.org/constitution/Seychelles_2017.pdf?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Seychelles_2017.pdf?lang=en)
18. CONSTITUTIONAL PROHIBITIONS OF THE DEATH PENALTY, Constitution of the Republic of Namibia (1990), <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2021/06/act500061996en.pdf>

19. https://www.constituteproject.org/constitution/Colombia_2015.pdf?lang=en
20. <https://pdba.georgetown.edu/Constitutions/Ecuador/english08.html>
21. The Spanish Constitution, Article 15, <https://www.boe.es/legislacion/documentos/ConstitucionINGLES.pdf>
22. https://www.constituteproject.org/constitution/Chile_2015.pdf?lang=en
23. Greece's Constitution of 1975 with Amendments through 2008, https://www.constituteproject.org/constitution/Greece_2008.pdf?lang=en
24. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2016\)064-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2016)064-e)
25. The Constitution OF THE REPUBLIC OF SOUTH AFRICA, 1996, Chapter 2, Article 11. <https://dearsouthafrica.co.za/wp-content/uploads/2018/05/SACConstitution-web-eng.pdf> https://www.constituteproject.org/constitution/Finland_2011.pdf?lang=en
26. Madagascar's Constitution of 2010, https://www.constituteproject.org/constitution/Madagascar_2010.pdf?lang=en
27. Malta's Constitution of 1964 with Amendments through 2016, https://www.constituteproject.org/constitution/Malta_2016.pdf?lang=en

ХАВСРАЛТ 1. ЦААЗААР АВАХ ЯЛТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЭХ СУРВАЛЖИЙН ЛАВЛАГАА

Монгол Улсад, цаазаар авах ялын талаар судалсан байдлын хүрээнд эх сурвалж цуглуулж, лавлагаа бэлтгэв. Үүнд : Докторын зэрэг горилсон бүтээл 2 (шууд холбоотой дагнасан сэдвээр 1, дам холбоотой сэдвээр 1); Магистрын зэрэг хамгаалсан ажил – 13; Ном, гарын авлага, судалгааны тайлан, эмхэтгэл – 11; Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл – 26 багтаж байна. Эдгээр нийт 52 эх сурвалжийг 4 төрлөөр ангилж, зохиогчийн нэр, бүтээлийн нэр, огноо, хэвлэгдсэн газар, цахимаар татаж үзэх холбоос хаяг зэрэг мэдээллийн хамт жагсаавал:

Докторын зэрэг горилсон бүтээл - 2

1. Амарбаясгалан Б. “Цаазаар авах ял: Олон улсын болон Монголын эрүүгийн эрх зүйн уялдаа холбоо, чиг хандлага”. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. 2013 он
2. Авхиа Ж. “БНМАУ-д санаатай хүн амины гэмт хэрэгтэй явуулах эрүүгийн эрхийн тэмцэл”, Хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. 1968 он

Магистрын зэрэг хамгаалсан ажил - 13

1. Батдорж М. “Цаазаар авах ялын харьцуулсан судалгаа”, Монгол Улсын Их Сургууль, Уб, 2006
2. Мөнгөнчимэг Ц. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ял: уламжлал ба шинэчлэл”, Монгол Улсын Их Сургууль, Уб, 2010
3. Рэнчинболд Э. “Монгол улс дахь цаазаар авах ял ба түүнийг халахтай холбоотой эрх зүйн орчин: үр дагавар ба эрсдлээс сэрэмжлэх нь”, Монгол Улсын Их Сургууль, Уб, 2012
4. Хишигбуян С. “Монгол Улс дахь цаазаар авах ялын онол, практикийн зарим асуудал”. Монгол Улсын Их Сургууль Уб, 2003
5. Батсайхан Д. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазар авах ял, уламжлал шинэчлэлийн зарим асуудал”, Хууль сахиулахын их сургууль, Уб, 2001
6. Мөнх-Эрдэнэ А. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ялын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Хууль сахиулахын их сургууль, Уб, 2008
7. Төрболд Н. “Монгол улс дахь цаазаар авах ялын эрх зүйн асуудал”, Отгонтэнгэр их сургууль, Уб, 2010
8. Төрбат П. “Монгол улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ялын уламжлал, шинэчлэлийн асуудал”, Их засаг их сургууль, Уб, 2009
9. Амарбаясгалан Б. “Цаазаар авах ял: уламжлал ба шинэчлэл”, Батлан хамгаалахын их сургууль, Уб, 1999
10. Мөнгөнчимэг Ц. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ял, түүний уламжлал ба шинэчлэл”, Батлан хамгаалахын их сургууль, Уб, 2010
11. Тэлмүүн Д. “Цаазаар авах ялын онол, практикийн зарим асуудал”, Билиг дээд сургууль, Уб, 2014
12. Алтанчулуу О. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаазаар авах ял: уламжлал ба шинэчлэлийн тулгамдсан асуудал”, Монголын Үндэсний дээд сургууль Уб, 2006
13. Ганзориг Д. “Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, тэмцэх арга зам”, Шихихутуг хууль зүйн дээд сургууль, Уб, 2009

Ном, гарын авлага, судалгааны тайлан, эмхэтгэл - 11

1. Г.Совд, БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. Уб, 1971
2. Б.Содовсүрэн, БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. Уб, 1971
3. Амарбаясгалан Б нар. Цаазаар авах ял ба хүний эрх. Уб, 2006
4. Амарбаясгалан Б. Цаазаар авах ял: Эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал. Уб, 2015
5. Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх. Уб, 2002
6. Шударгаар шүүлгэх эрх:гарын авлага. /Эмнести интернэшнл/ Уб, 2014
7. “Хүний амьд явах эрх ба цаазаар авах ял”, Эмнести интернэшнл байгууллага, Уб, 2006, https://nhrcm.gov.mn/media/documents/1431398013_2006-caazaar-avah-yalyn-sudalgaa.pdf
8. “Үндсэн хууль ба цаазаар авах ял”, Эмнести интернэшнл байгууллага, Уб, 2018
9. Ш.Хишигсүрэн, Цаазаар авах ялын байдал, хандлага, байр суурь судалгаа, . УИХ-ын тамгын газрын Судалгааны төв, Б.Хатантуул. (бодлогын судалгаа), шинжилгээ. 5-р боть Уб, 2010
10. Үндэсний хөгжлийн хүрээлэн, Учир шалтгааныг нь тайлбарлах тусам ард түмэн ойлгодог /Амьд явах эрх ба цаазаар авах ял социологийн судалгааны тайлан/. Амьд явах эрхийг хамгаалах үндэсний нийгэмлэг, Уб, 2011
11. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын нэгдэн ороогүй хүний эрхийн олон улсын гэрээний судалгаа. Судалгааны эмхэтгэл. 2-р боть.. Уб, 2011

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл – 26

1. Амарбаясгалан Б. “Цаазаар авах ялын орчин үеийн чиг хандлагын талаархи зарим асуудал”, Монголын төр, эрх зүй. 2006. №2. 46-56 дахь тал
2. Амарбаясгалан Б. “Цаазлах ялын тухайд” Эрх зүй онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал, 2010, №1-2 (18-19). 95-102 дахь тал
3. Бат-Ерөөлт Б. “Цаазаар авах ялын онол, практикийн зарим асуудал”, “Шихихутуг” эрх зүйн шинжлэх ухааны онол арга зүйн сэтгүүл. 2005. №1-2. 72-79 дэх тал
4. Бат-Эрдэнэ Б. “Монгол Улсад цаазаар авах ялтай гэмт хэргийг хуульчилж ирсэн байдал ба цаазаар авах ялын тухай үзэл баримтлал”, Монголын төр, эрх зүй. 2008. №4 (56). 2-5 дахь тал
5. Буджав Ж. “Жам ёсны эрх зүйн онол ба цаазаар авах ял: онол, арга зүй”, “Эрх зүй” онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал. 2010. №1-2 (18-19). 14-18 дахь тал
6. Дашбямба Б. “Цаазаар авах ялыг халах замаар замнахуй: амьд явах эрхийн тухайд”, Хүний эрх. 2004. №2. 52-56 дахь тал
7. Жанцан С. “Монгол Улсын ялын бодлого ба цаазаар авах ял”. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2010. №4 (34). 26-31 дэх тал
8. Мөнхөө Н. “Цаазаар авах ялын тухайд, Монголын төр, эрх зүй, 2009. №1 (57). 25-31 дэх тал
9. Отгончулуун Ч. “Амьд явах эрх ба цаазаар авах ял”, Хүний эрх. 2009, №2. 41-45 дахь тал
10. Оюунболд Г., Түвшинтулга А. “Монгол Улсад цаазаар авах ялыг халах уу, аль эсвэл...” Хууль дээдлэх ёс. 2010. №1 (28). 88-91 дэх тал
11. Оюунчимэг Ю. “Цаазаар авах ял ба эрүү шүүлт”, Хууль дээдлэх ёс. 2009. №3 (26). 87-90 дэх тал

12. Совд Г. “Монгол Улсын эрүүгийн цааз /хууль/-ыг өөрчлөх үзэл баримтлал”, Монголын төр, эрх зүй, 1995. №1. 6-15 дахь тал
13. Совд Г. “Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар”. Монголын төр, эрх зүй. 1995. №4. 29-36 дахь тал
14. Совд Г. “Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар”, Үргэлжлэл. Монголын төр, эрх зүй, 1996. №1. 31-41 дэх тал
15. Совд Г. “Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар”, Үргэлжлэл. Монголын төр, эрх зүй, 1996. №2. 45-55 дахь тал
16. Совд Г. “Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар/. Үргэлжлэл. Монголын төр, эрх зүй. 1996. №3. 40-49 дэх тал
17. Совд Г. Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар”, Үргэлжлэл. Монголын төр, эрх зүй, 1996. №4. 59-70 дахь тал
18. Совд Г. “Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар”, Үргэлжлэл. Монголын төр, эрх зүй. 1997. №1. 40-50 дахь тал
19. Түвшинтулга А. “Монгол Улсад цаазаар авах ялыг халах уу, аль эсвэл...” . “Өмгөөлөгч” мэдээлэл, танин мэдэхүйн сар тутмын сэтгүүл. 2010. №37. 25-28 дахь тал
20. Амарбаясгалан Б. “Цаазаар авах ялын талаархи онолын үндэслэл, үзэл баримтлал”, Эрх зүй. 2013, №1
21. Мөнхсайхан О. “Монгол Улсын Үндсэн хууль ба цаазаар авах ял”, Эрх зүй. №3(43) 2018,
22. Намсрай Б. “Аргагүй хамгаалалт ба амьд явах, халдашгүй байх эрхийн харилцан хамаарлын тухай”, Монголын төр, эрх зүй. 2006. №4. 31-44 дэх тал
23. Солонго А. “Хүний амьд явах эрхийг хангахад төрийн үүрэг оролцоо”, Хүний эрх. 2010. №1. 61-65 дахь тал
24. Ц.Сарантуяа. “Амьд явах эрхийг Үндсэн хуулиар хамгаалах нь”, Хууль дээдлэх ёс, №2 2017,
25. Ганбаатар Г. “Амьдрах эрх, амин эрх ашиг, үнэт зүйлсийн онцгой хамгаалалт: Эрүүгийн хуулийн шинэчлэлийн бодлого, зохицуулалт, анхаарах зарим асуудал”, Монголын төр, эрх зүй, №4, 2013,
26. Энх-Амгалан Б. “Олон улсын гэрээнд нэгдэхэд судалгаатай хандах асуудал Орчин үеийн олон улсын эрх зүйн харилцааны шинэ чиг хандлага ба Монгол Улс”, 2011, 143 дахь тал https://nli.gov.mn/pdf/olon_ulsiin_gereend_negden_oroh.pdf

ХАВСРАЛТ 2. ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХАД ЧИГЛЭСЭН НЭМЭЛТ II ПРОТОКОЛД НЭГДСЭН ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ЦААЗААР АВАХ ЯЛТАЙ ХОЛБООТОЙ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ЛАВЛАГАА⁵⁹

Энэхүү хүснэгт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт хоёрдугаар протоколд нэгдсэн 90 улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хууль тогтоомж дахь цаазаар авах ялтай холбоотой зохицуулалтын лавлагаа болно.

№	Улс	Үндсэн хуульд цаазын ялтай холбоотой заалт байгаа эсэх	Эрүүгийн хуульд цаазаар авах ял байгаа эсэх	Тайлбар (бусад байдлаар тусгагдсан гэх мэт)
1	БҮГД НАЙРАМДАХ АЛБАНИ УЛС	Албани улсын Үндсэн хуулийн 21-р зүйлд “Хүний амьд явах эрх хуулиар хамгаалагдана” гэж заасан боловч цаазаар авах ялтай холбоотой заалт байхгүй байна. ⁶¹	Бүгд Найрамдах Албани Улсын Эрүүгийн хуульд 3 үндсэн төрлийн ял болох бүх насаар нь хорих, хугацаатай хорих, торгох ялыг заасан бөгөөд цаазаар авах ял байхгүй байна. ⁶² “Хамгийн хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шүүх бүх насаар нь хорих ялаар шийтгэнэ. Бүх насаар нь хорих ялыг гэмт хэрэг үйлдэж байх үеийн арван найман нас хүрээгүй, эмэгтэй хүнд хэрэглэхгүй” хэмээн Эрүүгийн хуулийн 31-р зүйлд заасан байна. ⁶³	-
2	АНДОРРЫН ХАНТ УЛС	Андоррагийн хант Улсын Үндсэн хууль (1993)-ийн “Эрх, эрх чөлөө” бүлгийн 8-р зүйлийн 3-т “Цаазаар авах ялыг хориглоно.” хэмээн заасан байна. ⁶⁴	Байхгүй	-

59 Тус лавлагааг ХЗҮХ-ийн ХЗСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд бэлтгэв. Үүнд хийсэн дүн шинжилгээг Судалгааны тайлангийн 3 дугаар бүлгээс үзнэ үү.

60 European commission for democracy through law (venice commission), Albania constitution, Холбоос: [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF\(2016\)064-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-REF(2016)064-e), Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

61 Criminal code of the Republic of Albania, Холбоос: https://adsdatabase.ohchr.org/IssueLibrary/ALBANIA_Criminal%20Code.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

62 Criminal code of the Republic of Albania, Холбоос: https://adsdatabase.ohchr.org/IssueLibrary/ALBANIA_Criminal%20Code.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

63 Constitutional Prohibitions of the Death Penalty, Холбоос: <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2021/06/act500051999en.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

3	БҮГД НАЙРАМДАХ АНГОЛ УЛС	Ангол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд "Цаазаар авах ялыг хориглоно" хэмээн заасан. ⁶⁵	Байхгүй	2013 оны 9-р сарын 24-нд Ангол улс нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт хоёрдугаар протоколд гарын үсэг зурсан.
4	БҮГД НАЙРАМДАХ АРГЕНТИН УЛС	Аргентин Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд «бүх улс төрийн холбогдолтой гэмт хэрэгт цаазаар авах, эрүү шүүлт тулгах, тарчлаан зовоохыг бүр мөсөн хална» хэмээн заасан байна. ⁶⁶	Байхгүй	-
5	БҮГД НАЙРАМДАХ АРМЕНИ УЛС	Арменийн Үндсэн хуулийн 24-р зүйлд зааснаар 1. Хүн бүр амьд явах эрхтэй. 2. Хэнийг ч дур мэдэн амь насыг нь бусниулж болохгүй. 3. Хэнд ч цаазаар авах ял оногдуулж болохгүй хэмээн заасан ⁶⁷ .	2003 оны 8-р сарын 1-ний өдөр Бүгд Найрамдах Армен Улсын шинэ Эрүүгийн хууль хүчин төгөлдөр болж, цаазаар авах ялыг хуулийн ерөнхий хэсгээс хассан. 2003 оны дөрөвдүгээр сарын 18-нд шинэ Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг бүх насаар нь хорих ялаар сольсон. Мөн 2003 оны Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгагдаж буй этгээдийг тухайн улсын хууль тогтоомжоор тухайн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахаар заасан бол Армени улс хүлээн авахгүйгээр өөр улсад шилжүүлэн өгч болохгүй" гэсэн заалтыг оруулсан. ⁶⁸	2021 оны 3-р сарын 19-ний өдөр Арменийн Засгийн газар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ОУЭЗБХ)-ын цаазаар авах ялыг халах зорилготой Нэмэлт хоёрдугаар протоколыг соёрхон баталсан. ⁶⁹ Арменийн Үндсэн хуульд цаазаар авах ялыг хориглож, амьд явах эрхийг хамгаалж баталгаажуулснаар цаазаар авах ялыг халсан.

64 Angola's Constitution of 2010, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Angola_2010.pdf?lang=en Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

65 Constitutional Prohibitions of the Death Penalty, Холбоос: <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2021/06/act500051999en.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

66 The Constitution of the Republic of Armenia, Холбоос: <https://www.president.am/en/constitution-2015/>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

67 The Criminal Code of the Republic of Armenia, Холбоос: https://www.unodc.org/res/cld/document/armenia_criminal_code_html/Armenia_Criminal_Code_of_the_Republic_of_Armenia_2009.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

68 Холбоос: <https://www.pgaction.org/news/armenia-ratifies-death-penalty-ban.html>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

6	АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС	байхгүй	байхгүй	Австралийн бүх мужууд 1985 он гэхэд цаазаар авах ялыг халсан. 2010 онд Холбооны засгийн газар Цаазаар авах ялыг дахин сэргээхийг хориглох тухай хууль тогтоомжийг баталсан ⁷⁰ . Мөн цаазаар авах ялаар шийтгэгдсэн этгээдийг цаазаар авах эрх бүхий бусад нутаг дэвсгэр руу шилжүүлэн өгөх, албадан гаргахыг хориглодог. ⁷¹
7	БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС	Бүгд Найрамдах Австри Улсын Үндсэн хуулийн 1968 оны шинэчилсэн найруулгаар нэмэлт өөрчлөлт оруулж, Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд: «Цаазын ялыг халсан» гэж заасан. ⁷²	байхгүй	1950 онд зөвхөн хүний амь насны эсрэг гэмт хэрэгт цаазаар авах ялыг оногдуулахыг хориглож байсан бол 1968 онд бүх төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оногдуулахыг албан ёсоор халсан байна. Австри нь ИБУТЭОУП-ын Нэмэлт Хоёрдугаар Протоколыг 1993 онд соёрхон баталж, Европийн холбооны хүний эрхийн 6-р Протоколд 1984 соёрхон баталж, , 13-р Протоколд 2004 онд тус тус нэгдэн орсон улс юм.
8	БҮГД НАЙРАМДАХ АЗЕРБАЙЖАН УЛС	Азербайжан улсын Үндсэн хуулийн Амьд явах эрхийн тухай 27-р зүйлийн III дахь хэсэгт зааснаар “Цаазаар авах ялыг бүрэн хүчингүй болгох хүртэл зөвхөн төрийн эсрэг гэмт хэрэг болон хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг онц хүнд гэмт хэрэгт хамгийн дээд хэмжээний ял оногдуулж болно ⁷³ гэж заасан.	1998 оны 2-р сарын 10-ны өдөр “Бүгд Найрамдах Азербайжан Улсад цаазаар авах ялыг халахтай холбогдуулан Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар цаазаар авах ялыг цуцалсан.	1998 оны 1-р сарын 22-нд Азербайжан улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазын ялыг халах зорилготой нэмэлт хоёрдугаар протоколд нэгдэн орсон. 2002 оны тавдугаар сард Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазын ялыг халах зорилготой нэмэлт хоёрдугаар протоколыг соёрхон батлахдаа Азербайжан улс дараахь мэдэгдлийг гаргажээ: “Бүгд Найрамдах Армени улсын эзлэгдсэн нутаг дэвсгэрт эдгээр нутаг дэвсгэрийг эзлэлээс чөлөөлөх хүртэл Протоколын заалтыг хэрэгжүүлэх баталгааг Бүгд Найрамдах Азербайжан Улс өгөх боломжгүй гэдгээ мэдэгдэж байна.

69 “Death penalty dead and buried”. The Age. Melbourne. 11 March 2010, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

70 Холбоос: <https://www.afp.gov.au/sites/default/files/PDF/IPS/AFP%20National%20Guideline%20on%20international%20police-to-police%20assistance%20in%20death%20penalty%20situations.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

71 Austria’s Constitution of 1920, Reinstated in 1945, with Amendments through 2009, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Austria_2009.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

72 The constitution of the Republic of Azerbaijan, Холбоос: https://www.stat.gov.az/menu/3/Legislation/constitution_en.pdf, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

9	БЕЛЬГИЙН ХААНТ УЛС	Бельгийн Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл. Хуулиас гадуур ямар ч шийтгэл ногдуулах, хэрэглэх боломжгүй. 14bis зүйл “Цаазаар авах ялыг халсан.” ⁷⁴	Байхгүй	1996 онд Бельги улс бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан. ⁷⁵
10	БҮГД НАЙРАМДАХ БЕНИН УЛС	Бенин улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйл “Хүн бүр амьд явах эрх, эрх чөлөөг эдэлж, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй.” ⁷⁶	Байхгүй	2016 онд бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан. ⁷⁷
11	БҮГД НАЙРАМДАХ БОЛИВИ УЛС	Болови улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Хүн бүр амьд явах, бие махбод, сэтгэл зүй, бэлгийн бүрэн бүтэн байдлыг хангах эрхтэй. Хэнийг ч эрүүдэн шүүж, харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь гутаан доромжилж болохгүй. Цаазын ял байхгүй.” ⁷⁸	Байхгүй	1997 онд энгийн гэмт хэргээс цаазын ялыг халж, 2013 онд бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан. ⁷⁹
12	БОСНИ-ХЕРЦЕГОВИН УЛС	Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг. “Босни-Герцеговин улсын нутаг дэвсгэрт байгаа бүх хүмүүс хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдэлнэ; Үүнд: а. Амьд явах эрх. б. Эрүүдэн шүүх, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжилж харьцах, шийтгэхгүй байх эрх...” ⁸⁰	Байхгүй	2001 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хоёр дахь нэмэлт протоколыг соёрхон баталж, бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан. ⁸¹
13	ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БРАЗИЛ УЛС	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Үндсэн хууль (1988) XLVII-ийн 5 дугаар зүйлд: “А) 84-р зүйлийн XIX хэсэгт зааснаар дайн зарласнаас бусад тохиолдолд цаазаар авах ял оногдуулахгүй.” ⁸²	Байхгүй	1979 онд энгийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан.

73 Belgium's Constitution of 1831 with Amendments through 2014, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Belgium_2014.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

74 Countries That Have Abolished the Death Penalty Since 1976, Холбоос: <https://deathpenaltyinfo.org/policy-issues/international/countries-that-have-abolished-the-death-penalty-since-1976>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

75 Benin's Constitution of 1990, https://www.constituteproject.org/constitution/Benin_1990.pdf?lang=en

76 Countries That Have Abolished the Death Penalty Since 1976, Холбоос: <https://deathpenaltyinfo.org/policy-issues/international/countries-that-have-abolished-the-death-penalty-since-1976>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

77 Bolivia (Plurinational State of)'s Constitution 2009, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Bolivia_2009?lang=en

78 Countries That Have Abolished the Death Penalty Since 1976, Холбоос: <https://deathpenaltyinfo.org/policy-issues/international/countries-that-have-abolished-the-death-penalty-since-1976>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

79 Bosnia and Herzegovina's Constitution of 1995 with Amendments through 2009, Холбоос: https://www.constituteproject.org/constitution/Bosnia_Herzegovina_2009.pdf?lang=en, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

80 Countries That Have Abolished the Death Penalty Since 1976, Холбоос: <https://deathpenaltyinfo.org/policy-issues/international/countries-that-have-abolished-the-death-penalty-since-1976>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

81 Constitutional prohibitions of the death penalty, Constitution of the Federative Republic of Brazil (1988), Холбоос: <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2021/06/act500061996en.pdf>, Сүүлд үзсэн огноо: 2022.06.27.

14	БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛС	28 дугаар зүйл "Хүн бүр амьд явах эрхтэй. Хүний амь насанд халдах аливаа оролдлого бол хамгийн хүнд гэмт хэрэгт тооцогдоно." ⁸²	Байхгүй	1998 онд бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан. ⁸⁴
15	БҮГД НАЙРАМДАХ КАБО-ВЕРДЕ УЛС	Бүгд Найрамдах Кабо Верде улсын үндсэн хууль (1981 онд батлагдсан) 26 дугаар зүйлийн 2-т: "...ямар ч тохиолдолд цаазаар авах ял оногдуулахгүй. "Амьд явах, бие махбодийн болон оюун санааны бүрэн бүтэн байх эрх". ⁸⁵	Байхгүй	1981 онд бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан. ⁸⁶
